



Энэ сонгог гүйцэтгэл  
2011 оны 07 дугаар сарын 04  
№25 /694/

**ҮГИШЛАГЪ**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

1110

**Хөдөө аж ахуйн гаралтай  
бараа, түүхий эдийн биржийн  
тухай**

Монгол Улсын  
хууль

1134

**Улсын тэмдэгтийн хураамжийн  
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын  
Засгийн газрын  
тогтоол

1194

**Иргэдийг орон сууцжуулах  
талаар авах зарим арга  
хэмжээний тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |      |
|------|---|------|
| 274. | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн<br>биржийн тухай  | 1110 |
| 275. | Худалдаа, аж үйлдвэрийн тахирмын тухай хуульд<br>нэмэлт оруулах тухай   | 1121 |
| 276. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр<br>бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд<br>нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1122 |
| 277. | Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт,<br>өөрчлөлт оруулах тухай  | 1134 |
| 278. | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай<br>хуульд өөрчлөлт оруулах тухай   | 1175 |
| 279. | Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт<br>оруулах тухай   | 1176 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |      |
|------|--|------|
| 280. | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий<br>эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх<br>зарим арга хэмжээний тухай Дугаар 29 | 1176 |
| 281. | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний<br>тухай Дугаар 32  | 1178 |
| 282. | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний<br>тухай Дугаар 33  | 1179 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |      |
|------|---|------|
| 283. | Журам батлах тухай Дугаар 132   | 1180 |
| 284. | Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх,<br>зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар<br>батлах тухай Дугаар 134 | 1185 |
| 285. | Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим<br>арга хэмжээний тухай Дугаар 138   | 1194 |



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж

2.1.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай<sup>3</sup>, Компанийн тухай<sup>4</sup>, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль<sup>5</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Компанийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 34 дүгээрт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Үнэт цаасны зах зээлийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

3.1.1. "хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж" /цаашид "бирж" гэх/ гэж хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжааг тогтсон журмын дагуу зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээгээр болон энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан биржийн арилжааны төрөл, хэлбэрээр зохион байгуулдаг компанийг;

3.1.2. "биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд" /цаашид "бараа, түүхий эд" гэх/ гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг;

3.1.3. "биржийн арилжаанд оролцогч" гэж биржид бараа, түүхий эд арилжих зорилгоор бүртгүүлсэн, биржийн арилжаанд оролцох зөвшөөрөлтэй хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийг;

3.1.4. "биржийн арилжааны зах зээлд оролцогч" гэж бараа, түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, чанар, тоо хэмжээг тодорхойлох, хадгалах, тээвэрлэх, зуучлан арилжих, биржийн арилжааг зохион байгуулах, төлбөр тооцоог гүйцэтгэх, гарал үүслийг гэрчлэх, экспортлох үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээдийг;

3.1.5. "биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа" гэж бараа, түүхий эдийг гэрээний үндсэн дээр биржээр зуучлан арилжих ажиллагааг;

3.1.6. "биржийн арилжаа" гэж биржийн арилжаанд оролцогчдын хооронд байгуулах гэрээний үндсэн дээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг;

3.1.7. "биржийн дэнчин" гэж биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хэрэгжүүлэх баталгаа болгон энэ хуулийн 6.1-д заасан байгууллага дахь өөрийн дансанд урьдчилан байршуулсан мөнгийг;

3.1.8. "суудлын эрх" гэж биржийн арилжаанд тогтмол оролцох эрхийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ БИРЖ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 4 дүгээр зүйл. Бирж

4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн гаралтай бараа,

түүхий эдийн биржийн арилжааг зохион байгуулах төрөлжсөн нэг бирж үйл ажиллагаа явуулна.

4.2.Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг баримтална.

4.3.Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.

4.4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцож болно.

4.5.Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4.6.Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байна.

4.7.Бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн дор дурдсан иргэн, хуулийн этгээдэд урамшуулал олгох журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална:

4.7.1.хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо /цаашид "хоршоо" гэх/-ны гишүүн;

4.7.2.газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч.

4.8.Биржээс гадуурх бараа, түүхий эдийн арилжаанд биржийн нэр ашиглахыг хориглоно.

4.9.Биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

4.10.Энэ хуулийн 4.5, 5.1.7-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг төсвийн хөрөнгөөр худалдан авах бол биржээр дамжуулна.

4.11.Бирж нь өөрийн нэрийн өмнөөс болон бусад оролцогчийн нэрийн өмнөөс биржийн арилжаанд оролцохыг хориглоно.



## 5 дугаар зүйл.Биржийн чиг үүрэг

5.1.Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1.биржийн арилжааг зохион байгуулах;

5.1.2.биржийн байнгын гишүүн оролцогчид суудлын эрх олгох;

5.1.3.биржийн байнгын бус гишүүн оролцогчид биржийн арилжаанд оролцох зөвшөөрөл олгох;

5.1.4.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд<sup>6</sup> заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

5.1.5.биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох;

5.1.6.биржийн арилжаанд оролцогчийг шаардлагатай мэдээллээр хангах;

5.1.7.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах;

5.1.8.биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж магадлагаа гаргах;

5.1.9.биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх, бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох;

5.1.10.нэг хэлцлээр арилжих бараа, түүхий эдийн доод хэмжээг тогтоох;

5.1.11.стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох.

5.2.Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан дор дурдсан журмыг энэ хуулийн 8.1-д заасан Биржийн зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, мөрдүүлнэ:

<sup>6</sup> Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.



5.2.1.бараа, түүхий эдийг бэлтгэх, хаяглах, хадгалах, тээвэрлэх;

5.2.2.бараа, түүхий эдийг бүртгэх;

5.2.3.бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авах;

5.2.4.биржээр арилжих гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх;

5.2.5.биржийн арилжааг зохион байгуулах;

5.2.6.биржийн арилжааны үнэ бүрдэлтэд хяналт тавих;

5.2.7.биржийн арилжааны төлбөр тооцоо хийх;

5.2.8.энэ хуулийн 4.3-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах;

5.2.9.биржийн арилжаанд оролцогчийн үйл ажиллагааг зохицуулах;

5.2.10.энэ хуулийн 5.1.11-д заасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох;

5.2.11.биржээр арилжих бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах;

5.2.12. биржийн дэнчингийн хувь хэмжээг тогтоох;

5.2.13.баталгааны санд биржийн дэнчин байршуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

5.2.14.бусад.

#### **6 дугаар зүйл.Биржийн төлбөр тооцоо, хадгаламж**

6.1.Бирж нь биржийн гэрээний төлбөрийн үүргийг тодорхойлох, төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг бүртгэх, хадгалах үйлчилгээг гэрээний үндсэн дээр банк, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагаар гүйцэтгүүлэх, эсхүл уг үүргийг гүйцэтгэх тусгайлсан нэгж /цаашид "төлбөр тооцооны тус" гэх/ -тэй байна.

6.2.Энэ хуулийн 6.1-д заасан төлбөр тооцооны төв нь Үнэт цаасны

зах зээлийн тухай хуулийн 24, 25 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

6.2.1.талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүйгээс гарах хохирлын хэмжээг тодорхойлох;

6.2.2.гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргийг гүйцэтгүүлэх;

6.2.3.энэ хуулийн 6.2.2-т заасан үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор төлбөр тооцооны эрсдэлийг зохицуулах;

6.2.4.бусад.

## **7 дугаар зүйл.Биржийн арилжааны төрөл, хэлбэр**

7.1.Биржээр зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээг ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр дараах төрлийн гэрээг арилжина.

7.1.1.шууд арилжих гэрээ /spot/;

7.1.2.хугацаат гэрээ /форвард/ ;

7.1.3.нэг загварын гэрээ /фьючерс/;

7.1.4.ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ /опцион/.

7.2.Бараа, түүхий эдийг тогтоосон үнээр шууд, биет байдлаар нийлүүлэх гэрээг "шууд арилжих гэрээ" гэнэ.

7.3.Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон нөхцөлөөр, биет байдлаар ирээдүйд нийлүүлэх болон төлбөр гүйцэтгэх гэрээг "хугацаат гэрээ" гэнэ.

7.4.Бараа, түүхий эдийг тогтоосон хугацаанд, тохиролцсон үнээр ирээдүйд нийлүүлэх стандарт нөхцөл бүхий гэрээг "нэг загварын гэрээ" гэнэ.

7.5.Иргэний хуулийн 269.1-д заасан гэрээг "ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ" гэнэ.

## **8 дугаар зүйл.Биржийн зохицуулах зөвлөл**

8.1.Бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах



зорилготой орон тооны бус биржийн зохицуулах зөвлөл /цаашид "зохицуулах зөвлөл" гэх/-тэй байна.

8.2.Зохицуулах зөвлөл 13 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь үнэт цаас, хөдөө аж ахуй, худалдаа, зам, тээвэр, гааль, стандартчилал, чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс, 7 гишүүн нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдыг төлөөлсөн төрийн бус байгууллагын төлөөллөөс тус тус бүрдэнэ.

8.3.Зохицуулах зөвлөлийн гишүүдийг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

8.4.Зохицуулах зөвлөлийн дарга нь төрийн захиргааны байгууллагын төлөөлөл байх бөгөөд түүнийг зохицуулах зөвлөлийн гишүүдийн дотроос гишүүдийн олонхийн саналаар 3 жилийн хугацаагаар сонгоно.

8.5.Зохицуулах зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:

8.5.1.энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэл өгөх;

8.5.2.биржийн арилжааны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах;

8.5.3.биржийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөмж, дүгнэлт гаргах.

8.6.Зохицуулах зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

8.7.Зохицуулах зөвлөл үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнана.

8.8.Зохицуулах зөвлөл нь ажлын албатай байна.

## **9 дүгээр зүйл.Биржийн ажилтанд хориглох зүйл**

9.1.Биржийн ажилтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.1.1.биржийн арилжаанд оролцох;



9.1.2.биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн компани байгуулах;

9.1.3.биржийн арилжаанд оролцогчийн арилжааны нууцыг агуулсан мэдээ, мэдээллийг хувийн ашиг сонирхолд ашиглах, бусдад задруулах;

9.1.4.биржийн арилжааны зуучлагч /брокер/-тай үгсэн хуйвалдаж биржийн арилжааг шударга бусаар явуулах;

9.1.5.бараа, түүхий эдийн үндэд нөлөөлж болох мэдээллийг орхигдуулах, нуун дарагдуулах, зохих журмын дагуу мэдээлэл өгөхөөс татгалзах;

9.1.6.ажил, үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусад этгээдээс урамшуулал, мөнгөн шагнал, шан харамж авах.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ БИРЖИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОГЧ

### 10 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч

10.1.Биржийн арилжаанд оролцогчийг байнгын болон байнгын бус гишүүн оролцогч гэж ангилна.

10.2.Биржийн арилжааны зуучлагч /брокер/ нь үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байх бөгөөд биржийн байнгын гишүүн оролцогч байна.

10.3.Хоршоо нь байнгын бус гишүүн оролцогч байна.

10.4.Биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.4 болон энэ хуулийн 11.2.3, 11.2.6-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд авна.

10.5.Биржийн арилжаанд дараах этгээдийг оролцохыг хориглоно:

10.5.1.биржийн ажилтан;

10.5.2.даатгал, тусламжийн сан, тэдгээрийн ажилтан;

10.5.3.хууль тогтоомжоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон бусад этгээд.

10.6.Биржийн байнгын бус гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг биржээс авсан байна.

10.7.Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно.

10.8.Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн биржийн арилжаанд биржийн байнгын гишүүн оролцогчоор зуучлуулан оролцоно.

### **11 дүгээр зүйл.Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг**

11.1.Биржийн арилжаанд оролцогч нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

11.1.1.биржийн арилжааг ил тод, шударгаар явуулах;

11.1.2.стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгүүлж, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулсан бараа, түүхий эдийг арилжих;

11.1.3.бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг биржид үнэн зөв мэдээлэх, бүртгүүлэх;

11.1.4.энэ хуулийн 11.1.3-т заасныг зөрчсөнөөс худалдан авагчид учирсан хохирлыг тухайн арилжаанд оролцогч хариуцан барагдуулах;

11.1.5.биржийн арилжааны мэдээллийг ашиглах;

11.1.6.биржийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

11.2.Биржийн байнгын гишүүн оролцогч нь энэ хуулийн 11.1-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

11.2.1.суудлын эрх авах;

11.2.2.энэ хуулийн 7.1.1-7.1.4-т заасан гэрээ байгуулсны үндсэн дээр биржийн арилжаанд тогтмол оролцох;

11.2.3.бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх;

11.2.4.биржийн арилжааны сүлжээнд холбогдсон байх;



11.2.5.эрх бүхий байгууллагаас зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;

11.2.6.итгэмжлэгдсэн лаборатори, тээврийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх.

## **12 дугаар зүйл.Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл**

12.1.Биржийн арилжаанд оролцогчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.1.1.биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн болон түүний бараа, түүхий эдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

12.1.2.харилцан тохиролцох замаар биржээр арилжих бараа, түүхий эдийн үнийн түвшинд хязгаар тогтоох;

12.1.3.өөрийн болон биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн бараа, түүхий эдийг үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шенж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;

12.1.4.хууль тогтоомжоор хориглосон бусад үйл ажиллагаа.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ**

### **13 дугаар зүйл.Аудит**

13.1.Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж дүгнэлт гаргана.

13.2.Үндэсний аудитын газар энэ хуулийн 13.1-д заасан дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.

### **14 дүгээр зүйл.Биржийн тайланг нийтэд мэдээлэх**

14.1.Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.



## ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

### 15 дугаар зүйл.Биржийн үйл ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэх

15.1.Биржийн гэрээ байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд шүүхэд гомдол гаргаж болно.

15.2.Биржтэй холбогдсон маргаантай асуудлыг арбитраар шийдвэрлүүлж болно.

### 16 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Хедөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эрх бүхий улсын байцаагч зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах хариуцлага хүлээлгэнэ:

16.1.1.энэ хуулийн 4.8-д заасныг зөрчиж биржийн нэр ашиглан бараа, түүхий эдийг худалдсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.2.энэ хуулийн 12.1-д заасныг зөрчсөн биржийн байнгын бус гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байнгын гишүүн оролцогчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлогыг хураах, энэ зөрчлийг давтан гаргавал бирж дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох;

16.1.3.энэ хуулийн 9.1-д заасныг зөрчсөн биржийн ажилтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, үгсэн хуйвалдаж биржийн арилжаанд оролцсон оролцогчийн зөвшөөрлийг цуцлах, хууль бусаар олсон орлогыг хураах;

16.1.4.бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг үнэн зөв



мэдээлж, бүртгүүлээгүйгээс биржийн арилжаанд оролцогчид учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх, үгсэн хуйвалдсан арилжаанд оролцогчийн зөвшөөрлийг цуцлах, хууль бусаар олсон орлогыг хураах.

**17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

17.1.Энэ хуулийг 2012 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 06 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

"3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан бараа нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржээр арилжих бараа бол түүний гарал үүслийг биржийн тодорхойлолтыг үндэслэн гэрчилнэ."

**2 дугаар зүйл.**Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "экспортын" гэсний өмнө "энэ хуульд өөрөөр заагаагүй бол" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/5 дугаар зүйлийн 5.1.23 дахь заалт:**

"5.1.23."ерөнхий гэрээ" гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч, гүйцэтгэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг."

#### **2/8 дугаар зүйлийн 8.11, 8.12 дахь хэсэг:**

"8.11.Бараа, ажил, үйлчилгээг ерөнхий гэрээ байгуулан худалдан авахаар тендер зарлаж болно.

8.12.Ерөнхий гэрээ байгуулах журам, зааврыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

#### **3/28 дугаар зүйлийн 28.7.5 дахь заалт:**

"28.7.5.эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ."

#### **4/34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь заалт:**

"34.1.7.хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зарим онцгой эм, эмнэлгийн хэрэгслийг олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах шаардлагатай гэж үзсэн бол."

**5/36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэг:**

"36.6.Дэлгэрэнгүй жагсаалтад санал ирүүлэх хугацааг ажлын 7-оос доошгүй өдрөөр тогтооно."

**6/36 дугаар зүйлийн 36.17 дахь хэсэг:**

"36.17.Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд зөвлөхийн хураангуй жагсаалтыг дахин гаргаж, санал ирүүлэх хугацааг ажлын 5 ба түүнээс дээш өдрөөр тогтооно."

**7/39 дүгээр зүйлийн 39.15 дахь хэсэг:**

"39.15.Бага үнийн аргыг хэрэглэх тохиолдолд санал ирүүлэх хугацааг ажлын 5 ба түүнээс дээш өдрөөр тогтооно."

**8/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг:**

"44.3.Урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнд гүйцэтгэлийн баталгааны дүнг оруулан тооцож болно."

**9/46 дугаар зүйлийн 46.1.9 дэх заалт:**

"46.1.9.гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах."

**10/47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэг:**

"47.5.Энэ хуулийн 47.4-т заасан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилох, ажиллах журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

**11/52 дугаар зүйлийн 52.1.15 дахь заалт:**

"52.1.15.захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийх журмыг тогтоох."

**12/52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэг:**

"52.3.Хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагыг



энэ хуулийн 35-39 дүгээр зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж, захиалагчийн үйл ажиллагаа, гэрээний биелэлт, чанарт явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, аудит хийлгэж болно.”

**13/52<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“52<sup>1</sup> дүгээр зүйл.Худалдан авах ажиллагааны улсын байцаагч**

52<sup>1</sup>.1.Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий улсын ахлах байцаагч, улсын байцаагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад байна.

52<sup>1</sup>.2.Худалдан авах ажиллагааны улсын байцаагч нь худалдан авах үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

52<sup>1</sup>.2.1.энэ хуулийн 14.1.4, 14.1.6, 14.1.7-д заасан нөхцөл үүссэн нь тогтоогдсон тендерт оролцогчийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах тухай санал гаргах;

52<sup>1</sup>.2.2.энэ хуулийн 57.2-т заасан зөрчил гаргасан албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлүүлэх тухай дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

52<sup>1</sup>.2.3.энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус гэрээг цуцлах;

52<sup>1</sup>.2.4.гэрээний үүргийг гуривдагч этгээдэд захиалагчийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлсэн, тендерийн баримт бичигт урьдчилан заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн төлбөр хийсэн гэрээг цуцлах.”

**2 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “бүрт” гэсний дараа “шалгараагүй үндэслэлийн хамт” гэж, 52 дугаар зүйлийн 52.1.11 дэх заалтын “үзүүлэх” гэсний дараа “мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтыг зохион байгуулах журмыг батлах,” гэж, 55 дугаар зүйлийн 55.3, 55.4 дэх хэсгийн “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар” гэсний өмнө “Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг:**

"24.5.Төндөр нээснээс хойш тухайн төндөр шалгаруулалтыг 45 хоногт багтаан зохион байгуулж дуусгах бөгөөд уг хугацаанд төндөр хүчинтэй байна."

**2/29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсэг:**

"29.4.Захиалагчаас үл хамаарах шалтгаанаар төндөр хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулах боломжгүй болсон бол захиалагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, зөвшөөрөл авсны үндсэн дээр уг хугацааг нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

29.5.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 29.4-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянаж, захиалагчийн ирүүлсэн баримт бичиг, мэдээлэл болон бусад тодруулгад үндэслэн шийдвэрлэнэ."

**3/32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг:**

"32.2.Хязгаарлагдмал төндөр шалгаруулалт явуулахдаа захиалагч энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд төндөрийн урилгыг нийтэлж, сонирхогч этгээдийг төндөр шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана."

**4/45 дугаар зүйлийн 45.2-45.7 дахь хэсэг:**

"45.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна:

45.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн захиргааны төв болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллага, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь өөрийн хэрэгцээнд худалдан авах бүх бараа, ажил, үйлчилгээний хувьд;

45.2.2.аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд.



45.3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна.

45.4.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь энэ хуулийн 45.2, 45.3-т зааснаас бусад болон энэ хуулийн 45.5-д заасан улсын болон бүс нутгийн чанартай бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна.

45.5.Тухайн төсвийн жилд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор Засгийн газар батална.

45.6.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно.

45.7.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах байгууллага болон хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг Зэвсэгт хүчний тухай хуулийн 4.3, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 120.5-д заасны дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзвэл төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр энэ хуулийн 7.1.1-д заасан нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно."

#### **5/47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалт:**

"47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно."

#### **6/47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсэг:**

"47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна."

#### **7/47 дүгээр зүйлийн 47.9 дэх хэсэг:**

"47.9.Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа,



урамшууллыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.”

**8/48 дугаар зүйл:**

**“48 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааг төлөвлөх**

48.1.Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

48.2.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн гаргаж, төсвийн төслийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

48.3.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор энэ хуулийн 45.4-т заасан худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.

48.4.Төсвийн ерөнхийлөн захирагч болон худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

48.5.Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

48.6.Худалдан авах ажиллагааг төлөвлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**9/53 дугаар зүйл:**

**“53 дугаар зүйл.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага, түүний чиг үүрэг**

53.1.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь энэ хуулиар эрх олгосон худалдан авах ажиллагааг зохион байгуулах,



хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.

53.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын даргатай, дүүргийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны нэгжийн даргыг дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөн томилж, чөлөөгнө.

53.4.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын болон нэгжийн дарга нь ял шийтгэлгүй, төрийн албанд 10-аас доошгүй жил, үүнээс худалдан авах ажиллагааны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байна.

53.5.Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь энэ хуульд заасан захиалагчийн эрх, үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

53.5.1.худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

53.5.2.худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах;

53.5.3.худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, саналаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

53.5.4.худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох, боловсронгуй болгох;

53.5.5.захиалагч болон тендерт оролцогчдыг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдэнд сургалт зохион байгуулах;



53.5.6. худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын чадаах, техник техонологи, программ хангамжийн хүчин чадлыг сайжруулах асуудлыг нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;

53.5.7. энэ хуулийн 5.1.23-т заасан ерөнхий гэрээг байгуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

53.5.8. худалдан авах ажиллагааны үйл ажиллагаатай холбоотой хуульд заасан бусад чиг үүрэг.

53.6. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

53.7. Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь өөрийн гүйцэтгэх ажлын тодорхой хэсгийг хувийн хэвшлийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна."

#### **10/55 дугаар зүйлийн 55.1, 55.2 дахь хэсэг:**

"55.1. Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөнийг хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс өмнө Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 өдрийн дотор гаргана.

55.2. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зөвхөн гэрээ байгуулахаас өмнө гаргасан гомдлыг хянан хэлэлцэх бөгөөд гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэх ба энэ нь эцсийн шийдвэр болно."

#### **11/56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг:**

"56.1. Гомдлыг энэ хуулийн 55.2-т заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрвөл тендерт оролцогч нь шүүхэд гомдол гаргаж болно."



**12/57 дугаар зүйл:**

**"57 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

57.1.Энэ хуульд заасан журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэлийг шүүх, эсхүл эрх бүхий улсын байцаагч ногдуулна:

57.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэх худалдан авах ажиллагаанд уг журмыг хэрэглээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.2.тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо энэ хуулийн 8.4, 8.5, 8.7.1-д заасныг зөрчсөн бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.3.энэ хуулийн 9.2-т заасныг зөрчиж, гадаадын этгээдийг тендер шалгаруулалтад оруулахыг хязгаарласан бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.4.давуу эрхийн зөрүүг үнэлгээнд хэрэглэхдээ энэ хуулийн 10.1-10.3-т заасныг зөрчсөн үнэлгээний хэсгийн гишүүдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.5.тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэхдээ төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгоогүй нөхцөлд албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.6.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасныг зөрчиж тендерийн баримт бичгийг боловсруулалгүйгээр урилга нийтлүүлсэн, тендер шалгаруулалт явуулсан бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.7.тендерийн урилгыг зарлан мэдээлэхдээ энэ хуулийн 21.3, 21.4-т заасныг зөрчсөн бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;



57.1.8.энэ хуулийн 22.2-т заасныг зөрчиж тендерийн баримт бичгийн үнийг үндэслэлгүйгээр өндөр тогтоосон бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.9.нээлттэй тендер шалгаруулалтын үед энэ хуулийн 24.3-т заасныг зөрчиж тендер хүлээн авах эцсийн хугацааг 30-аас бага хоногоор тогтоосон, эсхүл зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох үед энэ хуулийн 36.10-т заасан санал ирүүлэх доод хугацааг мөрдөөгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.10.энэ хуулийн 24.5, 29.4-т заасан хугацаанд захиалагчаас хамаарах шалтгаанаар гэрээ байгуулаагүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.11.энэ хуулийн 26.6-д заасныг зөрчсөн бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.12.энэ хуулийн 27.1, 30.1-д зааснаас бусад үндэслэлээр тендерээс татгалзаж, тендер шалгаруулалтыг хүчингүй болгосон бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.13.энэ хуулийн 28.2-т заасныг зөрчиж тендерийн үнэлгээг үндэслэлгүйгээр тендер хүчинтэй байх хугацаанд хийгээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.14.захиалагч тендер шалгаруулалтыг шударга бус явуулж, энэ хуулийн 29.1-д заасныг зөрчиж, "хямгийн сайн" үнэлэгдээгүй тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон, энэ хуулийн 29.4-т заасныг зөрчиж гэрээний хугацааг сунгасан албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.15.энэ хуулийн 29.2-т заасныг зөрчиж гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 өдрийн дотор гэрээ байгуулсан бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.16.энэ хуулийн 32.1, 33.1, 34.1-д зааснаас бусад





нөхцөлд тендер шалгаруулалтын онцгой журам хэрэглэсэн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.17.энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.18.энэ хуулийн 47.1-д заасныг зөрчиж үнэлгээний хороо байгуулаагүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.19.энэ хуулийн 47.2.2-т заасан үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэлгүйгээр өөрчилсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.20.энэ хуулийн 48, 49 дүгээр зүйлд заасныг зөрчиж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг зарлаагүй, тухайн тендер шалгаруулалтад холбогдох хавтаст хэрэг бүрдүүлээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.21.энэ хуулийн 48.2, 49.5-д заасныг зөрчиж худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хуульд заасан хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.22.энэ хуулийн 54.4-т заасныг зөрчиж гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй бол албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

57.1.23.улсын ахлах байцаагч, байцаагч нь энэ хуулийн 57.1-д заасныг зөрчиж захиргааны шийтгэл оногдуулсныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон бол түүнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

57.2.Энэ хуулийн 57.1-д заасан зөрчлийг давтан гаргасныг шүүх, эрх бүхий улсын байцаагч тэгтгэсэн бол зэвхцэгчдийн ерөнхий мөхөөр, гүйцэтгэх захирал, үнэлгээний хорооны гишүүнийг төрийн албанаас халах шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан хүлээлгэнэ.

57.3. Энэ хуулийн 50.1-д заасныг зөрчсөн албан тушаалтныг тухайн албан тушаалаас нь халах сахилгын шийтгэлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээлгэнэ.

57.4. Энэ хуулийн 52' 2.2-т заасан үүргээ биелүүлээгүй улсын ажлах байцаагчид эрх бүхий албан тушаалтан Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэлийг хүлээлгэнэ.

57.5. Тендерт оролцогч болон аливаа этгээд нь худалдан авах гэрээний үүргээ зөрчсөн, биелүүлээгүй, тендерт оролцоходоо илт худал мэдүүлсэн, авлигын гэмт хэрэг үйлдсэнийг шүүх, эрх бүхий улсын байцаагч тогтоосон бол уг шийдвэрийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулна."

**4 дүгээр зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6 дахь заалтын "эрх бүхий байгууллага" гэснийг "энэ хуулийн 52' 1-д заасан эрх бүхий улсын байцаагч" гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн "эрх бүхий байгууллагын" гэснийг "энэ хуулийн 52' 1-д заасан эрх бүхий улсын байцаагчийн" гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "үйлчилгээ" гэснийг "зөвлөхийн бус үйлчилгээ, 100 сая төгрөгөөс дээш өртөгтэй зөвлөх үйлчилгээ" гэж, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн "1.000.000.001" гэснийг "10.000.000.001" гэж, 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсгийн "36.8.3-т" гэснийг "36.9.3-т" гэж, 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалтын "1 сарын 15-ны дотор" гэснийг "төсөв батлагдсан даруйд" гэж, 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийн "гишүүдийн олонхи нь" гэснийг "гишүүд" гэж, 36 дугаар зүйлийн 36.6-36.15 дахь хэсгийн дугаарыг "36.7-36.16" гэж, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсгийн дугаарыг "44.4" гэж, 47 дугаар зүйлийн 47.5-47.7 дахь хэсгийн дугаарыг "47.6-47.8" гэж, 52 дугаар зүйлийн 52.1.15 дахь заалтын дугаарыг "52.1.16" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн "энэ хуулийн 8.1.5-д заасан босго үнээс дээш өртөгтэй" гэснийг, 55 дугаар зүйлийн 55.3, 55.4 дэх хэсгийн "Өрсөлдөөний тухай хуульд заасан асуудлаар" гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.6 дахь заалт, мөн зүйлийн 34.4 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.1.9, 52.1.10 дахь заалт, 55 дугаар зүйлийн 55.5-55.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.



7 дугаар зүйл.Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### 1/13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт:

"13.1.7.уралдаан тэмцээнд оролцох зорилгоор ашиглах гадаадын иргэн, харьяалалгүй хүний галт зэвсгийг бүртгэж, улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн хуудас олгоход 20 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;"

#### 2/34 дүгээр зүйлийн 34.1.10 дахь заалт:

"34.1.10.цацраг идэвх" ашигт малтмал тээвэрлэх, ашиглалтын дараа газар сэргээх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг."

#### 3/41 дүгээр зүйлийн 41.4.13-41.4.15 дахь заалт:

"41.4.13.ойжуулалт, ойг нөхөн сэргээх, мод үржүүлэх чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох;

41.4.14.терийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд байгаль орчны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх;

41.4.15.түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлагаа, судалгаа хийх үйл ажиллагаа."

#### 4/42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэг:

"42.4.Энэ хуульд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн хугацааг

сунгахад хураах тэмдэгтийн хуралмжийн хэмжээг тухай бүрд нь заагаагүй бол энэ хуульд эдгээр тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийг олгоход хураахаар заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамжийг хураана;

**2 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3.7 дахь заалтын "Монгол Улсад суугаа" гэсний дараа "болон Монгол Улсаас гадаад улсад суугаа" гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/6 дугаар зүйл:**

**"6 дугаар зүйл. Тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох**

"6.1. Энэ хуулийн 6.2, 6.3-г зааснаас бусад тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуулиар тогтооно.

6.2. Энэ хуулийн 10.6, 11.2, 11.4, 11.5 дахь хэсэг, 12, 14-20 дугаар зүйл, 21.1.2-21.1.30 дахь заалт, 22, 24 дүгээр зүйл, 25.1.2, 25.1.3, 25.1.7-25.1.9, 26.1.6-26.1.9 дэх заалт, 26.2, 26.3 дахь хэсэг, 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалт, 27.2-27.4 дэх хэсэг, 28, 29 дүгээр зүйл, 30.2.2-30.2.6 дахь заалт, 30.3-30.5 дахь хэсэг, 31-33 дугаар зүйл, 35.1.1-35.1.3 дахь заалт, 37, 40 дүгээр зүйлд заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.

6.3. Энэ хуулийн 35.1.4-35.1.22 дахь заалт, 35.2-35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно."

**2/7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт:**

"7.1.1.эд хөрөнгийн чанартай үнэлж болох нэхэмжлэлд нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамаарч тэмдэгтийн хураамж нь дараах хэмжээтэй байх:

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хувь, хэмжээ /төгрөгөөр/
0-130 000	4550 төгрөг.
130 001-550 000	4550 төгрөг дээр 130 000 төгрөгөөс давсан дүнгийн 3 хувийг нэмнэ.



650 001-1 300 000	20150 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувийг нэмнэ.
1 300 001-13 000 000	35750 төгрөг дээр 1 300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ.
13 000 001-ээс дээш	222950 төгрөг дээр 13 000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.

### **3/10 дугаар зүйлийн 10.6, 10.7 дахь хэсэг:**

\*10.6.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгох, түүнийг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

10.6.1.гадаадын иргэнд тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

10.6.2.суралцах, мэргэжил дээшлүүлэх, дадлага, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгоход 12 000-30 000 төгрөг;

10.6.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэх олгох, солиход 7200-18 000 төгрөг;

10.6.4.гадаадын иргэн, харьяалалгүй хүний тус улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахад 36 000-90 000 төгрөг;

10.6.5.харьяалалгүй хүнд гадаадад зорчих үнэмлэх олгох, үнэмлэхний хугацаа сунгахад 4800-12 000 төгрөг;

10.6.6.гадаадын иргэнд хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгоход 1200-3000 төгрөг;

10.6.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүний оршин суух үнэмлэхэд оршин суугаа хаягийн өөрчлөлт, бусад тэмдэглэл хийх тухай бүр 1000-2500 төгрөг;

10.6.8.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэн, харьяалалгүй хүний баримт бичигт гадаадад зорчсон тэмдэглэл хийх тухай бүр 1000-2500 төгрөг;

10.6.9.Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгоход 1000-2500 төгрөг;



10.6.10.гадаадын иргэний талаар тодорхойлолт гаргахад 1000-2500 төгрөг;

10.6.11.гадаадын иргэн оршин суух болон зорчих үнэмлэхээ алдсан, үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосон тохиолдолд шинээр буюу дахин олгоход 36 000-90 000 төгрөг;

10.6.12.гадаадын иргэнийг бүртгэхэд 1000-2500 төгрөг;

10.6.13.гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1000-2500 төгрөг;

10.6.14.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд орон нутагт явахад зөвшөөрөл олгоход /хүн тус бүрээр/ 1000-2500 төгрөг;

10.6.15.нэг удаагийн орох болон гарах-орох виз олгоход 54 000-135 000 төгрөг;

10.6.16.хоёр удаагийн орох болон гарах-орох виз олгоход 81 000-202 500 төгрөг;

10.6.17.зургаан сарын олон удаагийн виз олгоход 126 000-315 000 төгрөг;

10.6.18.зургаан сараас нэг жил хүртэлх хугацаагаар олон удаагийн виз олгоход 252 000-630 000 төгрөг;

10.6.19.дамжин өнгөрөх нэг удаагийн виз олгоход 36 000-90 000 төгрөг;

10.6.20.дамжин өнгөрөх хоёр\* удаагийн виз олгоход 72 000-180 000 төгрөг;

10.6.21.дамжин өнгөрөх олон удаагийн виз олгоход 96 000-240 000 төгрөг;

10.6.22.хувийн хэрэг хөтөлж, регистрийн дугаар олгосон гадаадын иргэнд нэг болон хоёр удаагийн гарах-орох виз олгоход 18 000-45 000 төгрөг;

10.6.23.нэг визэд хавсаргасан иргэдийн визийг салгах, визийг шилжүүлэн олгоход 16 000-45 000 төгрөг;

10.6.24.визийн хугацааг долоо хүртэл хоногоор сунгахад



27 000-67 500 төгрөг, дараагийн хоног тутамд 3600-9000 төгрөг;

10.6.25.визийн ангилал өөрчлөхөд 36 000-90 000 төгрөг;

10.6.26.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээн ажиллуулах зөвшөөрөл өгч, гэрчилгээ олгоход 900 000-2 250 000 төгрөг;

10.6.27.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл өгч, гэрчилгээний хугацааг сунгахад 360 000-900 000 төгрөг;

10.6.28.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгоход 60 000-150 000 төгрөг;

10.6.29.Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлтийг хянан шийдвэрлүүлэхэд 60 000-150 000 төгрөг.

10.7.Энэ хуулийн 10.6-д заасан гадаадын иргэнд үзүүлэх үйлчилгээг яаралтай буюу хилийн боомт дээр үзүүлэх тохиолдолд хураамжийн хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн хураана."

#### **4/11, 12 дугаар зүйл:**

#### **"11 дүгээр зүйл.Консулын үйлчилгээ үзүүлэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

11.1.Гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.1.1.үндэсний энгийн гадаад паспорт олгоход 12 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.2.дипломат, албан паспорт олгоход 30 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.3.Монгол Улсад буцах үнэмлэх олгоход 22 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.1.4.үндэсний гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахад 2500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;



11.1.5.хүүхдийн үнэмлэх олгоход 2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.2.Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз олгоход энэ хуулийн 10.6-д заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана.

11.3.Консулын үйлчилгээг яаралтай үзүүлэх тохиолдолд энэ хуулийн 10.6-д заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг ажлын 8 цагийн дотор бол хоёр дахин нэмэгдүүлж, амралт, баяр ёслолын өдөр бол гурав дахин нэмэгдүүлэн хураана.

11.4.Консулын нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.4.1.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэл гэрчлэхэд 18 000-54 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.2.эд хөрөнгийн бус үнэлэх боломжгүй гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацаа сунгасныг гэрчлэхэд 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.3.эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ, дүрэм гэрчлэхэд 23 000-69 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.4.Монгол Улсын газрын харилцаанд холбогдох гэрээнээс бусад хэлцэл /гэрээ, итгэмжлэл зэрэг/-ийг гэрчлэхэд 52 000-156 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.5.баримт бичигт консулын баталгаа гаргахад 1500-4500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.6.баримт бичгийг болон баримт бичгийн хуулбарын үнэн зөвийг гэрчлэхэд хуудас тутмаас 1500-4500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.7.баримт бичгийн орчуулгыг гэрчлэхэд хуудас тутмаас 300-900 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.8.баримт бичигт зурсан гарын үсгийг гэрчлэхэд 2500-7500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;





11.4.9.гэрчлэгдсэн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд хуудас тутмаас 200-600 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.10.үйлчлүүлэгчийн хүсэлтээр үндсэн материалыг шалгахад 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.11.үл хөдлөх эд хөрөнгийн холбогдолтой баримт бичгийг гэрчлэхэд баримт бичигт тусгагдсан үнийн дүнгийн 0.06 хүртэл хувиар;

11.4.12.үл хөдлөх эд хөрөнгийн гэрээг гэрчлэхэд нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эхийн хувьд гэрээний үнийн дүнгээс 0.035 хүртэл хувиар, бусад хүнд үнийн дүнгийн 0.055 хүртэл хувиар;

11.4.13.энэ хуулийн 11.4.1-11.4.3, 11.4.7-д зааснаас бусад гэрээ, хэлцлийг гэрчлэхэд үнийн дүнгийн 1 000 000 хүртэл төгрөгөөс 0.025 хүртэл хувиар, 1 000 000 төгрөгөөс давсан хэсгээс 0.015 хүртэл хувиар нэмэгдүүлж;

11.4.14.хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ үзүүлэхэд үнийн дүнгийн 1.2 хүртэл хувиар;

11.4.15.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай гэрээ, дүрэм гэрчлэхэд хуудас тутмаас 240-720 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.16.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичиг гэрчлэхэд 4400-13 200 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.17.хуулийн этгээд үүсгэн байгуулах, татан буулгах баримт бичигт өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг гэрчлэхэд 1100-3300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют ;

11.4.18.хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөн байгуулах эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг гэрчлэхэд 2000-6000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.19.аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл болон зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг гэрчлэхэд 20 000-60 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;



11.4.20.өв залгамжлах эрх, гэрээслэл гэрчлэхэд 1100-3300 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.4.21.гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эрхийг гэрчлэхэд 1000-2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

11.5.Өв залгамжлал, гэрээслэл, гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбоотой гэрээ зэрэг тодорхой үнийн дүн, төлбөрийн хэмжээ бүхий бүх төрлийн гэрээ, хэлцлийг гэрчлэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

11.5.1.1000 хүртэл ам.доллартай тэнцэх дүнтэй бол 15 000-45 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.2.1001-10000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 23 000-69 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.3.10001-25000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 30 000-90 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.4.25001-100000 ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 37 000-111 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.5.100001-300000 ам. доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 45 000-135 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.6.300001 болон түүнээс дээш ам.доллартай тэнцэх үнийн дүнтэй бол 60 000 -180 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.7.өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, эцэг, эхээс бусад хүнд өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход 100 000-300 000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

11.5.8.аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг нотлох бүх төрлийн баримт бичгийн хуулбарыг гэрчлэхэд 7500-22 500 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.



**12 дугаар зүйл.Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг  
бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах  
тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

12.1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.1.1.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр олгоход 1000-2000 төгрөг;

12.1.2.автотээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, мэргэшсэн жолоочийн үнэмлэх олгоход 1000-2000 төгрөг;

12.1.3.автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтрийг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 8000-20 000 төгрөг;

12.1.4.өөрөө явагч хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгоход 1000-2000 төгрөг.

12.2.Автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн дугаар олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.2.1.автомашинны дугаар олгоход 1000-2200 төгрөг;

12.2.2.өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар олгоход 1000-2000 төгрөг;

12.2.3.мотоциклийн улсын дугаар олгоход 1000-2000 төгрөг;

12.2.4.автомашин, өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн болон мотоциклийн улсын дугаарыг алдаж үрэгдүүлэх, гээгдүүлэх, хүчингүй буюу ашиглах боломжгүй болгосноос дахин олгоход 15 000-40 000 төгрөг.

12.3.Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авсан бол түүнийг зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа орон нутаг дахь байгууллага бүртгэхэд 1000-2000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

12.4.Агаарын хөлөг болон усан онгоцыг бүртгэх, агаарын



тээвэрлэгчийн гэрчилгээ, усан /хөлөг/ онгоцыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

12.4.1.Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэж, үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 17 600-44 000 төгрөг;

12.4.2.гадаадын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд байгаа агаарын хөлгийг Монгол Улсын иргэний агаарын тээвэрт ашиглахаар гэрээ байгуулсан нөхцөлд улсын бүртгэлд бүртгэж үндэсний таних тэмдэг, бүртгэлийн гэрчилгээ олгоход 200 000- 500 000 төгрөг;

12.4.3.энэ хуулийн 12.4.2-г заасан гэрчилгээний хугацааг сунгахад 160 000-400 000 төгрөг;

12.4.4.агаарын хөлгийг ашиглалтаас хасах, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулаагүй гадаадын байгууллагад болон Монгол Улсын харьяат бус бөгөөд тус улсад оршин суудаггүй хүнд худалдсан, шилжүүлсэн тохиолдолд улсын бүртгэлээс хасахад 12 000-30 000 төгрөг;

12.4.5.дотоодын усан замын тээврийн хэрэгслийг бүртгэж, дугаар, гэрчилгээ олгоход 4000-10 000 төгрөг;

12.4.6.төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчид буюу тэдгээрийн түрээслэсэн хөлөг онгоцыг Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэхэд 24 000-60 000 төгрөг."

#### **5/14-24 дүгээр зүйл:**

#### **14 дүгээр зүйл.Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

14.1.Сонин, сэтгүүл, радио, телевизийг улсын бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

14.1.1.сонин, сэтгүүлийг бүртгэж, гэрчилгээ олгоход 8800-22 000 төгрөг;

14.1.2.олон нийтийн болон хувийн радиог бүртгэхэд 12 800-32 000 төгрөг;



14.1.3.олон нийтийн болон хувийн телевизийг бүртгэхэд 40 000-100 000 төгрөг;

14.1.4.кабелийн телевизийг бүртгэхэд 48 000-120 000 төгрөг;

14.1.5.сонин, сэтгүүл, радио, телевиз, кабелийн телевизийн бүртгэлд өөрчлөлт орсныг бүртгэхэд 8000-20 000 төгрөг."

**15 дугаар зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээнд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

15.1.Хуулийн этгээдийн эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагаанд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.1.1.нөхөрлөл, компанийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 8800-22 000 төгрөг;

15.1.2.хоршоог бүртгэж, гэрчилгээ олгоход 5600-14 000 төгрөг;

15.1.3.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг бүртгэж, гэрчилгээ олгоход 14 000-35 000 төгрөг;

15.1.4.боловсролын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 6000-15 000 төгрөг;

15.1.5.эрүүл мэндийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 8000-20 000 төгрөг;

15.1.6.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 4000-10 000 төгрөг;

15.1.7.хуулийн этгээдийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, хугацааг нь сунгахад 1000-2200 төгрөг;

15.1.8.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгоход анх хураасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг;

15.1.9.улсын бүртгэлийн жагсгэлтас лавлагаа олгоход 1000-2000 төгрөг.

15.2.Улс төрийн нам, шашны болон төрийн бус байгууллага, сан, холбоо, хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

15.2.1.улс төрийн намыг бүртгэж, гэрчилгээ олгоход 60 000-150 000 төгрөг;

15.2.2.улс төрийн намын нэр сольсныг бүртгэхэд 20 000-50 000 төгрөг;

15.2.3.шашны байгууллагыг бүртгэж, гэрчилгээ олгоход 80 000-200 000 төгрөг;

15.2.4.төрийн бус байгууллага, сан, холбоо, хөдөлгөөнийг бүртгэж, гэрчилгээ олгоход 8800- 22 000 төгрөг.

**16 дугаар зүйл.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, түүний төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

16.1.Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

16.1.1.салбар, төлөөлөгчийн газар, нэгж ажиллуулахад 440 000-1 100 000 төгрөг;

16.1.2.салбар, төлөөлөгчийн газрын ажиллах хугацааг сунгахад 300 000-750 000 төгрөг;

16.1.3.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахад 300 000-750 000 төгрөг;

16.1.4.гэрчилгээний хугацааг сунгахад 30 000-75 000 төгрөг;

16.1.5.гэрчилгээг сольж олгоход анх олгоход хураасан тэмдэгтийн хураамж дээр 1.5 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр;

16.1.6.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын гэрээ, дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэхэд 14 000-35 000 төгрөг;



16.1.7.гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулах зөвшөөрөл олгоход 1 120 000- 2 800 000 төгрөг;

16.1.8.гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход 720 000-1 800 000 төгрөг.

**17 дугаар зүйл.Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

17.1.Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

17.1.1.банк байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 480 000-1 200 000 төгрөг;

17.1.2.мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

17.1.3.эээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 300 000-750 000 төгрөг;

17.1.4.төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 18 000-45 000 төгрөг;

17.1.5.өөрийн нэрийн өмнөөс гураадагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах тусгай зөвшөөрөл олгоход 74 000-185 000 төгрөг;

17.1.6.гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 70 000-175 000 төгрөг;

17.1.7.үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

17.1.8.үнэт зүйл хадгалах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

17.1.9.гадаад төлбөр тооцоо хийх тусгай зөвшөөрөл олгоход 180 000-450 000 төгрөг;

17.1.10.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл олгоход 48 000-120 000 төгрөг;



17.1.11.санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 180 000-450 000 төгрөг;

17.1.12.зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл олгоход 48 000-120 000 төгрөг;

17.1.13.гадаад улсад банк байгуулах зөвшөөрөл олгоход 1 280 000-3 200 000 төгрөг;

17.1.14.гадаад улсад банкны салбар байгуулах зөвшөөрөл олгоход 480 000-1 200 000 төгрөг.

17.1.15.энэ хуулийн 17.1.1-17.1.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 40 000-200 000 төгрөг;

17.1.16.хууль тогтоомжоор хориглоогүй, Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 52 000-130 000 төгрөг.

**18 дугаар зүйл.Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

18.1.Банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.1.1.арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

18.1.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээхэд 200 000-500 000 төгрөг;

18.1.3.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

18.1.4.актуарчийн эрх олгоход 140 000-350 000 төгрөг;

18.1.5.даатгагчид өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 112 000-280 000 төгрөг;

18.1.6.даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлт гаргаж, зөвшөөрөл авахад 40 000-100 000 төгрөг;





18.1.7.гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 1 800 000-4 500 000 төгрөг.

18.2.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.2.1.даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгоход 18 000-45 000 төгрөг;

18.2.2.даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл олгоход 26 000-65 000 төгрөг;

18.2.3.даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгоход 34 000-85 000 төгрөг.

18.3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

18.3.1.зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 120 000-300 000 төгрөг;

18.3.2.факторингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

18.3.3.хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 80 000-200 000 төгрөг;

18.3.4.төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

18.3.5.төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

18.3.6.цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

18.3.7.гадаад валютын үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 800 000-2 000 000 төгрөг;

18.3.8.итгэлцлийн үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;



18.3.9.богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

18.3.10.үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

18.3.11.банк бус санхүүгийн байгууллагын нэр, байршлыг өөрчлөх зөвшөөрөл олгоход 4000-10 000 төгрөг;

18.3.12.банк бус санхүүгийн байгууллагыг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахад Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг олгоход 24 000-60 000 төгрөг;

18.3.13.үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож, бүртгэхэд 13 000-30 000 төгрөг;

18.3.14.үнэт цаасны төлбөр тооцооны болон хадгаламжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

18.3.15.үнэт цаасны хамтын хөрөнгө оруулалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

18.3.16.үнэт цаасны хөрөнгө оруулалтын сангийн зөвшөөрөл олгоход 48 000-120 000 төгрөг;

18.3.17.андеррайтер, брокер, дилер, үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 58 000-145 000 төгрөг;

18.3.18.хөрөнгө оруулалтын менежментийн болон хөрөнгө оруулалтын зөвлөхөөр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 112 000-280 000 төгрөг;

18.3.19.банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

18.3.20.компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон худалдах зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

18.3.21.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

18.3.22.барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэл хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;



18.3.23.хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг.

**19 дүгээр зүйл.Санхүү, эдийн засгийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

19.1.Санхүү, эдийн засгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эрх олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

19.1.1.нийгмийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000-5 000 000 төгрөг;

19.1.2.аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

19.1.3.үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 2 200 000-5 500 000 төгрөг;

19.1.4.эд мөнгөний хонжворт сугалаа гаргах тусгай зөвшөөрөл олгоход 240 000-600 000 төгрөг;

19.1.5.хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 96 000-240 000 төгрөг;

19.1.6.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 340 000-850 000 төгрөг;

19.1.7.гаалийн баталгаат бүсэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 800 000-4 500 000 төгрөг;

19.1.8.Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрхийн хугацааг сунгах шалгалтад тэнцсэн иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, түүний хугацааг сунгахад 8000-20 000 төгрөг.

**20 дугаар зүйл.Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

20.1.Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



20.1.1.өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

20.1.2.нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 4000-10 000 төгрөг;

20.1.3.төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 860 000-2 150 000 төгрөг;

20.1.4.тамга, тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 880 000-2 200 000 төгрөг.

**21 дүгээр зүйл.Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

21.1.Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

21.1.1.Химийн хорт болон аюултай бодисын тухай<sup>1</sup> хуулийн 6.4-т заасан жагсаалтад орсон бодисыг импортлох, худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг;

21.1.2.химийн хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 200 000-3 000 000 төгрөг;

21.1.3.химийн хорт болон аюултай бодис экспортлох, устгах тусгай зөвшөөрөл олгоход 8000-20 000 төгрөг;

21.1.4.химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 10 000-25 000 төгрөг;

21.1.5.химийн хорт болон аюултай бодис худалдах тусгай зөвшөөрөл олгоход 200 000- 500 000 төгрөг;

21.1.6.тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг;

<sup>1</sup> Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 25 дугаарт нийтлэгдсэн.



21.1.7.стандартаар хүлцэх хэмжээг нь тогтоогоогүй бохирдуулах бодис агаарт гаргах тусгай зөвшөөрөл олгоход 800 000-2 000 000 төгрөг;

21.1.8.байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

21.1.9.озон задалдаг бодисыг системээс юүлэх, цэвэрлэх, дахин цэнэглэх, засвар үйлчилгээ хийх, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

21.1.10.озоны давхаргыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй бодис импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоход 11 000-27 000 төгрөг;

21.1.11.озон задалдаг бодисын хольц агуулсан дараах тоног төхөөрөмж импортлох, худалдах зөвшөөрөл олгоход:

21.1.11.а.гэр ахуйн хөргөгч, хөлдөөгч 10 000-25 000 төгрөг;

21.1.11.б.иргэн, олон нийтийн барилга, орон сууцны агааржуулагч, хөргөх хэрэгсэл 20 000-50 000 төгрөг;

21.1.11.в.үйлдвэр болон томоохон зочид буудлын хөргөх систем 40 000-100 000 төгрөг;

21.1.12.ховор амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргах нэг удаагийн зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг;

21.1.13.ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 1200-3000 төгрөг, тарималжуулсан нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 600-1500 төгрөг;

21.1.14.элбэг амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад 60 000-150 000 төгрөг;

21.1.15.элбэг ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад



тухайн үеийн жингийн килограмм тутамд 1000-2500 төгрөг;

21.1.16.нэн ховор ургамлын эд, эрхтэнийг судалгаа, шилжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд:

21.1.16.а.үр 60 000- 150 000 төгрөг;

21.1.16.б. наьч, найлзуур, иш 18 000- 45 000 төгрөг;

21.1.16.в.үндэс 100 000 - 250 000 төгрөг.

21.1.17.ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 4000-10 000 төгрөг, ховор ургамлыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 6000-15 000 төгрөг, түүхий эд бүтээгдэхүүн 20 000-50 000 төгрөг;

21.1.18.элбэг ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход 0-3 килограмм бол 1800-4500 төгрөг, 3 килограммаас дээш бол 1800-4500 төгрөг дээр 3 килограммаас дээш хуурай жингийн килограмм тутамд 600-1500 төгрөг нэмж;

21.1.19.эрх бүхий байгууллагаас импортлох, экспортлохыг зөвшөөрсөн ургамалд үзэлг шалгалт хийж хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 0-10 килограмм бол 1000-1500 төгрөг, 10 килограммаас дээш бол 1000-1500 төгрөг дээр 10 килограммаас дээш килограмм тутамд 100-150 төгрөг нэмж;

21.1.20.100 шоометр хүртэлх ус ашиглах зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг, 100, түүнээс дээш шоометр ус ашиглах зөвшөөрөл олгоход 80 000-200 000 төгрөг;

21.1.21.энэ хуулийн 21.1.22-21.1.25, 41.4.13-т зааснаас бусад чиглэлээр байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх шинээр олгоход 20 000-50 000 төгрөг, сунгахад 12 000-30 000 төгрөг;

21.1.22.усны эрэл, хайгуул, судалгааны ажил явуулах, усны шинжилгээ, аудит хийх мэргэжлийн байгууллагын эрх олгоход 340 000-850 000 төгрөг, сунгахад 200 000-500 000 төгрөг;

21.1.23.усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, цооног өрөмдөх, худаг гаргах, сэргээн засварлах, шинэчлэх, усны барилга байгууламж барих, тоноглох, газрын хэвлийн нөхөн сэргээлт, ан агнуурын ажил эрхлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгоход 200 000-500 000 төгрөг, сунгахад 120 000-300 000 төгрөг;



21.1.24.ойд үндсэн ашиглалтын огтлолт, ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хуш модны самар бэлтгэх, боловсруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлөх ажил эрхлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгоход 120 000-300 000 төгрөг, сунгахад 60 000-150 000 төгрөг;

21.1.25.эмийн болон ашигт ургамал бэлтгэх, нөхөн сэргээх чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрх олгоход 80 000-200 000 төгрөг, сунгахад 40 000-100 000 төгрөг;

21.1.26.аюултай хог хаягдлыг экспортлох, ашиглах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 8000-20 000 төгрөг;

21.1.27.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдах тухай Конвенцийн хавсралтад орсон ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох буюу импортлох зөвшөөрөл, реэкспортлох буюу далай, тэнгисээс олборлон оруулах зөвшөөрөл, гэрчилгээ олгоход аж ахуйн нэгж, байгууллагаас 260 000-650 000 төгрөг, иргэнээс 100 000-250 000 төгрөг, бэлэг дурсгалын зориулалттай зүйл гаргах зөвшөөрөл олгоход ширхэг тутамд 20 000-50 000 төгрөг;

21.1.28.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын Амьтны аймгийн тухай<sup>2</sup> хуулийн 17.3-т заасан амьтны цуглуулгыг судалгаа, шинжилгээний зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход 100 000-250 000 төгрөг, бусад зориулалтаар гадаадад гаргах зөвшөөрөл олгоход 300 000-750 000 төгрөг;

21.1.29.хувиргасан амьд организмыг үйлдвэрлэх эрх олгоход 1 200 000-3 000 000 төгрөг, судалгаа, шинжилгээний зориулалтаар хувиргасан амьд организмыг гарган авах, туршилт явуулах эрх олгоход 48 000-120 000 төгрөг;

21.1.30.хувиргасан амьд организм экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх зөвшөөрөл олгоход 1 200 000-3 000 000 төгрөг.

**22 дугаар зүйл.Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

22.1.Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

<sup>2</sup> Амьтны аймгийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2000 оны 19 дугаарт нийтлэгдсэн.



22.1.1.их сургууль, дээд сургууль, коллеж байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

22.1.2.мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт эрхлэх зөвшөөрөл олгоход 160 000-400 000 төгрөг;

22.1.3.магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг, зөвшөөрлийг сунгахад 20 000-50 000 төгрөг;

22.1.4.дээд боловсролын байгууллага шинэ мэргэжлээр бакалаврын сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 120 000-300 000 төгрөг;

22.1.5.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгоход 160 000-400 000 төгрөг;

22.1.6.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

22.1.7.боловсролын магадлан итгэмжлэл олгоход 105 000-260 000 төгрөг;

22.1.8.дахин магадлан итгэмжлэл олгоход 35 000-85 000 төгрөг;

22.1.9.түүх, соёлын хосгүй үнэт зүйлийг бүртгэх, гэрчилгээ олгоход 1000-2000 төгрөг;

22.1.10.улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрөл олгоход 26 000-65 000 төгрөг;

22.1.11.хот, суурин, барилга байгууламж барих шгнээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хь туул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход археологи, палеонтологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл олгоход 40 000-300 000 төгрөг;

22.1.12.түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг, шаардлагатай бол хугацааг сунгахад 12 000-30 000 төгрөг.





**23 дугаар зүйл.Түлш, эрчим хүчний чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

23.1.Эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/, шугам сүлжээ барьж байгуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

23.1.1.0.1-5МВт-ын эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/ барих, угсрах зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.1.2.5-100МВт-ын эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/ барих, угсрах зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.1.3.100МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр /нар, салхи, ус болон түлшээр ажилладаг/ барих, угсрах зөвшөөрөл олгоход 37 500 төгрөг;

23.1.4.0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.1.5.110-220кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.1.6.220кВ-оос дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засварын ажлын зөвшөөрөл олгоход 37 500 төгрөг;

23.1.7.туршилт тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэхэд 12 500 төгрөг;

23.1.8.нүүрсээр ажиллах эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулах зөвшөөрөл олгоход 1 МВт тутамд 50 000 төгрөг, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах зөвшөөрөл олгоход 1МВт тутамд 25 000 төгрөг;

23.1.9.эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, диспетчерийн зохицуулалт хийх, цахилгаан импортлох, экспортлох, түгээх, хангах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход зөвшөөрөл тус бүрд 1 000 000 төгрөг.

23.2.Зуух, даралтат сав, шугам хоолойн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



23.2.1.0.7-40.0 кгх/см кв. даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.2.2.40.0 кгх/см кв-аас дээш даралттай зуух, даралтат савны засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

23.2.3.0.7-40.0 кгх/см кв. даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 12 500 төгрөг;

23.2.4.40.0 кгх/см кв-аас дээш даралттай шугам хоолойн засвар, угсралтын ажил эрхлэх зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг.

23.3.Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр олгох тусгай зөвшөөрөлд дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

23.3.1.сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг;

23.3.2.бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчид эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход 75 000 төгрөг;

23.3.3.бие даасан үүсгүүрээр сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчид эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл олгоход 60 000 төгрөг.

**24 дүгээр зүйл.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

24.1.Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хурвана:

24.1.1.Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

24.1.2.зуучлах зөвшөөрлийг сунгахад 80 000-200 000 төгрөг;

24.1.3.гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад зуучлах тусгай зөвшөөрөл олгоход 3 200 000-8 000 000 төгрөг;

24.1.4.Засгийн газраас гадаадын иргэнд улсын онц чухал



объект гэж тогтоосон газар ажиллах зөвшөөрөл олгоход 340 000-850 000 төгрөг.”

**6/25 дугаар зүйлийн 25.1.2, 25.1.3 дахь заалт:**

“25.1.2.аж ахуйн нэгж, байгууллага хэрэгцээнээс илүүдэлтэй тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг худалдах зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаас олгоход 20 000-50 000 төгрөг;

25.1.3.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас олгоход тухай бүр 10 000- 25 000 төгрөг.”

**7/25 дугаар зүйлийн 25.1.7-25.1.9 дэх заалт:**

“25.1.7.төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

25.1.8.үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 80 000-200 000 төгрөг;

25.1.9.үнэт металл, эрдэнийн чулуугаар эдлэл хийх үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл олгоход 800 000-2 000 000 төгрөг.”

**8/25 дугаар зүйлийн 25.1.10.а, 25.1.10.б дэх заалт:**

“25.1.10.а.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 5 000 000 төгрөг;

25.1.10.б.газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр:

25.1.10.б.1.автобензин, дизель түлш, онгоцны түлшний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 000 төгрөг;

25.1.10.б.2.хийн түлшний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000 төгрөг;

25.1.10.б.3.жижиглэн савласан /220гр-500гр/ газрын тосны шингэрүүсэн хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг.”

**9/ 26-33 дугаар зүйл:**

**"26 дугаар зүйл.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

26.1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

26.1.1.тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 7 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 4 500 000 төгрөг;

26.1.2.спирт үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 100 000 000 төгрөг;

26.1.3.архи үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 100 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 50 000 000 төгрөг;

26.1.4.шар айраг үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 50 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 25 000 000 төгрөг;

26.1.5.дарс үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 20 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 10 000 000 төгрөг

26.1.6.таримал ургамлын үр үйлдвэрлэх зөвшөөрөл олгоход 50 000-125 000 төгрөг;

26.1.7.малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, тусгай зөвшөөрөл олгоход 240 000-600 000 төгрөг;

26.1.8.ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 8000-20 000 төгрөг;

26.1.9.малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, үржлийн сайжруулагч мал импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 80 000-200 000 төгрөг.



26.2. Үржлийн мал экспортод гаргах лиценз олгоход малын тоо толгой тутмаас дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 26.2.1. цэвэр үүлдрийн адуу 80 000-200 000 төгрөг;
- 26.2.2. үржлийн бусад адуу 60 000-150 000 төгрөг;
- 26.2.3. цэвэр үүлдрийн үржлийн үхэр 60 000-150 000 төгрөг;
- 26.2.4. үржлийн бусад үхэр 40 000-100 000 төгрөг;
- 26.2.5. цэвэр үүлдрийн гахай 7 200-18 000 төгрөг;
- 26.2.6. хонь 24 000-60 000 төгрөг;
- 26.2.7. ямаа 24 000-60 000 төгрөг;
- 26.2.8. тэмээ 120 000-300 000 төгрөг.

26.3. Малыг гүн хөлдөөсөн үр, хөврөл үр, бичил биетний өсгөвөр экспортод гаргахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

26.3.1. үржлийн малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үр 10 000-25 000 төгрөг;

26.3.2. мал эмнэлгийн зориулалттай вакцин, бусад бичил биетний өсгөвөр 52 000-130 000 төгрөг.

**27 дугаар зүйл. Эрүүл мэндийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураамж тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

27.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.1.1. эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, протез, ортопед үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрөл олгоход 44 000-110 000 төгрөг;

27.1.2. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

27.1.3. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, тэдгээрийн түүхийг эдийн засгийн үйлдвэрлэлд хөгжүүлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг, хугацааг сунгахад 200 000 төгрөг;

27.1.4.эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 120 000-400 000 төгрөг;

27.1.5.биологийн идэвхт үйлчилгээтэй бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

27.1.6.өвчнийг оношлох, эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ арга турших, нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход 8000-20 000 төгрөг.

27.2.Өвчин үүсгэгч нян, түүний хорыг өсгөвөрлөх, үржүүлэх, хадгалах, нөөцлөх, тээвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.2.1.импортын лиценз олгоход 6000-12 500 төгрөг;

27.2.2.экспортын лиценз олгоход 6000-12 500 төгрөг.

27.3.Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 20 000-50 000 төгрөг хураана.

27.4.Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

27.4.1.анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн их эмчид хоёр жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 4000-10 000 төгрөг;

27.4.2.мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт өгч тэнцсэн эм зүйч, эм найруулагч, хүний бага эмч, эх баригч, сувилагч болон энэ хуулийн 27.4.1-д заасан зөвшөөрлөөр хоёр жил ажилласан эмчид 5 жилийн хугацаатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 2000-5000 төгрөг;

27.4.3.анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эмчлэх, эм барих, сувилахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгоход 120 000-400 000 төгрөг.



**28 дугаар зүйл.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

28.1.Барилга, хот байгуулалтын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

28.1.1.барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

28.1.2.цамхаг, тулгуур, түшиц хана, яндан, антенна, цутгамал болон угсармал барилга, газар дээрх ба доорх тусгай зориулалтын барилга, инженерийн болон цахилгааны гол магистрал шугам, хий болон нефтийн агуулах, шатахуун түгээх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, усны барилга байгууламжийн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 1 000 000-2 500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 800 000-2 000 000 төгрөг;

28.1.3.барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

28.1.4.өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 80 000-350 000 төгрөг;

28.1.5.нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

28.1.6.цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалттай байгууламж, 16–аас дээш давхар барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх тухайн барилга байгууламжид зөвшөөрөл олгоход 960 000-2 400 000 төгрөг;

28.1.7.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;

28.1.8.хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөв, хот, тосгоны хөгжлийн өрөнхий төлөвлөгөө, үе шатны бусад зураг төслийг боловсруулах мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл олгоход 350 000-900 000 төгрөг.

28.1.9.барилгын засвар үйлчилгээ, орчны тохижилт,



түүх, соёлын барилга, мод ба өрөгт бүтээцэн барилга, барилгын өргөтгөл шивэтгэл, барилгын доторх инженер, цахилгаан хангамж, гал, холбоо дохиоллын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад 80 000-200 000 төгрөг.

**29 дүгээр зүйл.Зам, тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хурааж тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

29.1.Зам, тээвэр, аялал, жуулчлалын чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

29.1.1.төмөр замын суурь бүтэц барих, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000-5 000 000 төгрөг;

29.1.2.төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгоход 2 000 000-5 000 000 төгрөг;

29.1.3.төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 6 400 000-16 000 000 төгрөг;

29.1.4.хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрөл олгоход 400 000-1 000 000 төгрөг;

29.1.5.энэ хуулийн 29.1.4-т зааснаас бусад авто зам, замын байгууламж барих тусгай зөвшөөрөл олгоход ангилал тус бүр нь 120 000-300 000 төгрөг, авто зам, гүүр засварлах, арчлах зөвшөөрөл олгоход 120 000-300 000 төгрөг;

29.1.6.автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 112 000-280 000 төгрөг;

29.1.7.агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход 60 000-150 000 төгрөг;

29.1.8. нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоход 16 000-40 000 төгрөг;

29.1.9.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр:

29.1.9.а.дуцд оврын хөлөг онгоцонд 140 000-





350 000 төгрөг;

29.1.9.6.бага оврын усан онгоцонд 80 000-

200 000 төгрөг;

29.1.9.в.жижиг оврын моторт завинд 40 000-

100 000 төгрөг.

29.1.10.тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 580 000-1 450 000 төгрөг;

29.1.11.байнгын үйл ажиллагаатай аэродромыг улсын бүртгэлд бүртгэхэд 18 000-44 000 төгрөг.

**30 дугаар зүйл.Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

30.1.Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмлэх, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 200 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

30.2.Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

30.2.1.ярианы үйлчилгээ эрхлэхэд 1 000 000 төгрөг;

30.2.2.интернэт, егөгдөл дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 40 000-100 000 төгрөг;

30.2.3.телевиз, радиогийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд 32 000-80 000 төгрөг;

30.2.4.шуудангийн үйлчилгээ эрхлэхэд 20 000-50 000 төгрөг;

30.2.5.харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэхэд 20 000-50 000 төгрөг;

30.2.6.дамжуулан хүргэх, нэмэлт үйлчилгээ эрхлэхэд 12 000-30 000 төгрөг.

30.3.Контентийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

30.3.1.телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 20 000-50 000 төгрөг, аймагт 15 000-20 000 төгрөг;



30.3.2.радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 15 000-40 000 төгрөг, аймагт 6000-15 000 төгрөг;

30.3.3.кабелийн сувгийн үйлчилгээ эрхлэхэд нийслэлд 20 000-50 000 төгрөг, аймагт 10 000-20 000 төгрөг;

30.3.4.тусгай дугаар ашигласан мэдээлэл, лавлагааны үйлчилгээ эрхлэхэд 10 000-20 000 төгрөг;

30.3.5.контент агрегаторын үйлчилгээ эрхлэхэд 20 000-50 000 төгрөг.

30.4.Бүртгэлийн гэрчилгээ олгоход 10 000-20 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

30.5.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгоход 10 000-25 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

**31 дүгээр зүйл.Хэмжил зүйн чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

31.1.Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

**32 дугаар зүйл.Мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

32.1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд экспортын болон импортын гэрчилгээ, импортын мэдэгдэл олгоход 4000-10 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

**33 дугаар зүйл.Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

33.1.Гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

33.1.1.галын аюултай /газрын тосны бүтээгдэхүүн, шатамхай хий, шингэн/ болон тэсэрч дэлбэрэх бодис, материал хадгалах, ашиглахад галын аюулгүй байдлын зөвшөөрөл олгоход:



33.1.1.а.нефтийн бүтээгдэхүүн, шатдаг хийн агуулахад:

№	Нефтийн бүтээгдэхүүн, шатдаг хийн агуулахын багтаамж /куб.метр/	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
1	2000, түүнээс доош 50001-ээс дээш	120 000	300 000
2	2001-10000	200 000	500 000
3	10001-20000	280 000	700 000
4	20001-50000	320 000	800 000
5	50001-ээс дээш	400 000	1 000 000

33.1.1.б.шатахуун болон хий түгээх станцад  
40 000-100 000 төгрөг;

33.1.1.в.шатдаг хий жижиглэн борлуулахад  
6000-12 500 төгрөг;

33.1.1.г.тэсэрч дэлбэрэх бодис, материал  
ашиглахад 120 000-300 000 төгрөг;

33.1.2.барилга, байгууламжийг шэнээр барих зураг төсөлд хяналт хийн зөвшөөрөл олгоход:

№	Барилга байгууламжийн багтаамж, куб метр	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
1	3000 хүртэл	20 000	50 000
2	3001-10000	40 000	100 000
3	10001-ээс дээш	60 000	150 000

33.1.3. барилгын өргөтгөл болон хийц бүтээц, цахилгааны эх үүсвэр, шулам зүйлсэнд зэрэг төсөлд хяналт хийн зөвшөөрөл олгоход  
20 000-50 000 төгрөг;

33.1.4.Галын аюулгүй байдлын тухай хуулийн<sup>3</sup> 16.1.7-д заасны дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргахад 5000-12 500 төгрөг.”

**10/34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг:**

“34.2.Цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

34.2.1.рентген төхөөрөмжөөс бусад цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Цацрагийн үүсгүүрийн ангилал	Тоо ширхэг	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
Ангилал 1-ийн үүсгүүр	1-10	350 000
	10-20 хүртэл	550 000
	20-иос дээш	750 000
Ангилал 2-ын үүсгүүр	1-10	300 000
	10-20 хүртэл	500 000
	20-иос дээш	700 000
Ангилал 3-ын үүсгүүр	1-10	250 000
	10-20 хүртэл	450 000
	20-иос дээш	650 000
Ангилал 4-ийн үүсгүүр	1-10	200 000
	10-20 хүртэл	400 000
	20-иос дээш	600 000
Ангилал 5-ын үүсгүүр	1-10	150 000
	10-20 хүртэл	350 000
	20-иос дээш	550 000

<sup>3</sup> Галын аюулгүй байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 27 дугаарт нийтлэгдсэн.



34.2.2. рентген төхөөрөмжийг ашиглах, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход:

Рентген төхөөрөмж	Тоо ширхэг	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
1-р бүлэг	1-3	100 000
	4-6	300 000
	6-аас дээш	400 000
2-р бүлэг	1-3	300 000
	4-6	400 000
	6-аас дээш	600 000

**11/ 35-37 дугаар зүйл:**

**\*35 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

35.1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.1.1. улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 120 000-400 000 төгрөг;

35.1.2. гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдээс бусад этгээдэд эмчилгээний гоо заслын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход 200 000-500 000 төгрөг;

35.1.3. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах зөвшөөрлийг олгоход 150 000-250 000 төгрөг;

35.1.4. агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;



35.1.5.тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход  
100 000-250 000 төгрөг;

35.1.6.ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног  
өрөмдөх зөвшөөрөл олгоход 96 000-240 000 төгрөг;

35.1.7.ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс  
бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 32 000-80 000  
төгрөг, гэрээг сунгахад 20 000-50 000 төгрөг;

35.1.8.усны барилга байгууламж гэрээгээр эзэмших,  
ашиглах эрх олгох, эрх сунгахад 40 000-100 000 төгрөг;

35.1.9.ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход  
48 000-120 000 төгрөг;

35.1.10.нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ,  
соёл, урлаг, тоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах,  
зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь  
алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөг;

35.1.11.хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд  
тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй  
чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм  
хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход 8000-20 000 төгрөг;

35.1.12.ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий  
эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч  
гарал үүслийн тодорхойлолт олгоход 1000-5000 төгрөг;

35.1.13.үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан  
агнах, барих гэрээ байгуулахад 400 000-1 000 000 төгрөг;

35.1.14.мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин  
газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд  
гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 толгой мал бол 1000-5000 төгрөг,  
10-аас дээш тооны толгой мал бол 1000-5000 төгрөг дээр 10-аас дээш  
тооны малын толгой тутамд 50-100 төгрөг нэмж;



35.1.15.ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 1200-3000 төгрөг;

35.1.16.элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход 1000-2000 төгрөг;

35.1.17.элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд 4000-10 000 төгрөг;

35.1.18.ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход 0-10 килограмм бол 1000-2000 төгрөг, 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 50-100 төгрөг нэмж;

35.1.19.мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдэд олгоход 200 000-500 000 төгрөг, иргэнд 160 000-400 000 төгрөг;

35.1.20.мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоход 80 000-200 000 төгрөг;

35.1.21.мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 2000-5000 төгрөг;

35.1.22.рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход 125 000-320 000 төгрөг.

35.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:



35.2.1.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 400 000-1 000 000 төгрөг, аймгийн төвийн суманд 240 000-600 000 төгрөг, бусад суманд 120 000-300 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 120 000-300 000 төгрөг, аймгийн төвийн суманд 80 000-200 000 төгрөг, бусад суманд 40 000-100 000 төгрөг;

35.2.2.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 120 000-300 000 төгрөг, аймгийн төвийн суманд 80 000-200 000 төгрөг, бусад суманд 40 000-100 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 40 000-100 000 төгрөг, аймгийн төвийн суманд 30 000-70 000 төгрөг, бусад суманд 16 000-40 000 төгрөг;

35.2.3.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600 000-1500000төгрөг, аймгийн төвийн суманд 320000-800000 төгрөг, бусад суманд 200 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 200 000-500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-400 000 төгрөг, бусад суманд 80 000-200 000 төгрөг;

35.2.4.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 300 000-750 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-400 000 төгрөг, бусад суманд 100 000-250 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 160 000-400 000 төгрөг, аймгийн төвийн суманд 80 000-200 000 төгрөг, бусад суманд 50 000-120 000 төгрөг.

35.3.Энэ хуулийн 35.2.1-д заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.2 дахь заалт, энэ хуулийн 35.2.3-т заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.4 дэх заалт тус тус хамаарахгүй.

35.4.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000-100 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

35.5.Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

35.5.1.мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоход:





Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
6 м <sup>3</sup> хүртэл	1000	3000
6-10 м <sup>3</sup> хүртэл	1500	4500
10-20 м <sup>3</sup> хүртэл	2000	6000
20-60 м <sup>3</sup> хүртэл	5000	15000

35.5.2.ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
8 м <sup>3</sup> хүртэл	1500	4500
8-10м <sup>3</sup> хүртэл	2000	6000
10-20м <sup>3</sup> хүртэл	3500	10500
20-30м <sup>3</sup> хүртэл	5000	15000

35.5.3.ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/	Хураамжийн дээд хэмжээ /төгрөгөөр/
0-10 м <sup>3</sup>	1000	3000
10-20 м <sup>3</sup>	1200	3600
20-30 м <sup>3</sup>	1500	4500



35.5.4.арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 1000-2000 төгрөг, 10 куб метрээс дээш бол 1000-2000 төгрөг дээр 10-аас дээш сийрэг куб метр тутамд 100-150 төгрөг нэмж;

35.5.5.ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнэ, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 1000-2000 төгрөг, 10 куб метрээс дээш бол 1000-2000 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд 100-150 төгрөг нэмж.

**36 дугаар зүйл.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалтад гэрчилгээ олгох, зохиогчийн эрхийн бүтээлийг бүртгэж гэрчилгээ олгох, патентыг хүчинтэй байлгах, барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг сунгах, лицензийн гэрээг бүртгэхэд хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

36.1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээ олгох, зохиогчийн эрхийн бүтээл болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэж гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

36.1.1.шинэ бүтээлийн патент олгоход 2500 төгрөг;

36.1.2.бүтээгдэхүүний загварын патент олгоход 2500 төгрөг;

36.1.3.ашигтай загварын гэрчилгээ олгоход 2500 төгрөг;

36.1.4.барааны тэмдгийн гэрчилгээ олгоход 2500 төгрөг;

36.1.5.газар зүйн заалтын гэрчилгээ олгоход 2500 төгрөг;

36.1.6.зохиогчийн эрхийн бүтээл болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 2500 төгрөг.

36.2.Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

36.2.1.эхний 3 жилд 10 000 төгрөг;



- 36.2.2.4-6 жилд 20 000 төгрөг;
- 36.2.3.7-10 жилд 30 000 төгрөг;
- 36.2.4.11-15 жилд 40 000 төгрөг;
- 36.2.5.16-20 жилд 50 000 төгрөг.

36.3.Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

- 36.3.1.эхний 3 жилд 10 000 төгрөг;
- 36.3.2.4-6 жилд 20 000 төгрөг;
- 36.3.3.7-10 жилд 30 000 төгрөг.

36.4.Барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацааг 10 жилээр сунгахад 20 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

36.5.Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ олгосон ашигтай загвар, барааны тэмдгийг бусдад ашиглуулах болон технологи дамжуулах лицензийн гэрээг бүртгэхэд 2000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

### **37 дугаар зүйл.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ**

37.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэн, хуулийн этгээдийг шалгаруулж, зөвшөөрөл олгоход 40 000 - 100 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана."

**4 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.32 дахь заалтын "11.2.2, 23.1.1, 30.1-д" гэснийг "11.2.2-г" гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын "550" гэснийг "70 200" гэж, 7.1.3 дахь заалтын "55" гэснийг "100" гэж, 10 дугаар зүйлийн 10.3.4 дэх заалтын "200" гэснийг "1000" гэж, 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын "750 000" гэснийг "5 000 000" гэж, 13.1.6 дахь заалтын "500 000" гэснийг "2 000 000" гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын "25 000 000" гэснийг "100 000 000" гэж, 34.1.2 дахь заалтын "15 000 000" гэснийг "550 000 000" гэж, 34.1.9 дэх заалтын "25 000 000" гэснийг "250 000 000" гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.11 дэх заалтын "м<sup>2</sup> тутамд 2500 төгрөг" гэснийг "нийслэлд м<sup>2</sup> тутамд 500 төгрөг, аймагт м<sup>2</sup> тутамд 100 төгрөг" гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн "20 000" гэснийг "8000-20 000" гэж, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсгийн дугаарыг "42.5" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1 дэх заалтын "шинээр" гэснийг, 13 дугаар зүйлийн



13.1.3 дахь заалтын "уралдаан тэмцээнд оролцох" гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.1.5 дахь заалтын "тээвэрлэх," "ашиглалтын дараа газар сэргээх" гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.5 дахь хэсэг, мөн зүйлийн 10.3.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1.6-34.1.8 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1.2-38.1.21 дэх заалт, 41 дүгээр зүйлийн 41.4.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**8 дугаар зүйл.** Энэ хуулиар тэмдэгтийн хураамжийн хэмжээг нь бууруулан тогтоосон тухайн заалтыг 2011 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд энэ хуулиар хэмжээг нь бууруулан тогтоогоогүй бусад заалтад энэ хугацаа хамаарахгүй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн "12, 13 дугаар" гэснийг "14, 15 дугаар" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд 7.3.14 дэх заалт нэмсүгэй:

"7.3.14.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т заасан улсын тэмдэгтийн хураамж."

**2 дугаар зүйл.**Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн "7.4.10-7.4.12-т" гэсний дараа "болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т" гэж, 8.5 дахь хэсгийн "7.4.14-т" гэсний дараа "болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.3-т" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.4 дэх заалтын "энэ хуулийн 7.3.9-7.3.12-т" гэснийг "энэ хуулийн 7.3.14-т" гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн "7.3.9-7.3.12," гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.9-7.3.12 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 06 дугаар  
сарын 02-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар  
хот

**Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий  
эдийн биржийн тухай хуулийг  
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Мэргэжлийн Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай



хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Хоршооны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах, тус биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг батлах;

3/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаанд оролцох биржийн арилжааны зуучлагч /брокер/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршооны загвар бий болгох;

4/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаанд оролцогчдыг сургаж бэлтгэх, тус биржээр арилжих бараа, түүхий эдийн чанар, стандартын хэрэгжилтийг хангуулах сургалт зохион байгуулах, хууль сурталчлах үүрэг бүхий нэгжийг байгуулан Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хүртэлх хугацаанд ажиллуулах;

5/хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг хүлээн авч анхан шатны тордолт хийх байр, талбай, хадгалах агуулах, тээврийн судалгаа гаргаж, бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

6/энэ тогтоолд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төсөвт тусган санхүүжүүлэх.

2.Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам боловсруулж батлахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.



3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /П.Алтангэрэл/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

### **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/бүх салбарыг хамарсан бараа, ажил, үйлчилгээний стандарт, нийтээр дагаж мөрдөх норм нормативыг шинэчлэн боловсруулан баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах;

2/бараа, ажил, үйлчилгээний стандартыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны хүрээнд тендер шалгаруулах болон тендерийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих гол шалгуур үзүүлэлт байх журам тогтоож мөрдүүлэх;

3/бараа, ажил, үйлчилгээний стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, чанар стандартыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг чангатгах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Д.Хаянхярваа/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

### Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар/С.Батболд/-т даалгасугай:

1/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу Улсын Их Хурлаас тогтоосон хязгаарт багтаан улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 2011 оны 7 дугаар сарын 01-ний дотор тогтоох;

2/2011 оны 6 дугаар сарын 09-ны өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар төрийн зарим төрлийн үйлчилгээнд хураах улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг бууруулан тогтоож, энэхүү хураамжийг 2011 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн буцаан хэрэглэхээр заасны дагуу тухайн заалтад хамаарах 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр баталсан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу тэмдэгтийн хураамж төлсөн иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тэмдэгтийн хураамжийн зөрүүг буцаан олгох арга хэмжээ авах;

3/аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаан дахь төрийн оролцоог багасгах, шат дамжлагыг бууруулах шаардлагад нийцүүлэн тусгай зөвшөөрлийн тоог багасгах, хугацааг бодитой тогтоох, тусгай зөвшөөрлийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх асуудлыг судлан үзэх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/аж ахуйн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгож байгаа байдал, түүнийг зохицуулж байгаа хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хариуцлага тооцон ажиллах.





2.Хуулиар тогтоосон хязгаарт багтаан өөрийн бүрэн эрхэд хамаарах Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.3-т заасан төрийн зарим үйлчилгээний тэмдэгтийн хураамжийн хэмжээг 2011 оны 7 дугаар сарын 01-ний дотор тогтоон хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Д.Хаянхярваа/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2011 оны 6 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**ДДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 4 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 132

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup>.6, 26.3 дахь хэсгүүдийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан нөхөн төлбөр олгох ажлын явц, дүнг хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

3. Нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

**ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН  
ХОХИРОГЧИД ТӨРӨӨС НӨХӨН ТӨЛБӨР  
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан /цаашид "Сан" гэх/-гаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup>.2-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу 2011 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш үйлдэгдсэн энэ журмын 2.1-д заасан гэмт хэргийн хохирогчид хамаарна.

Хоёр. Сангийн зорилго, зохион байгуулалт,  
орон тооны хязгаар, удирдлага

2.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup>.2-т заасны дагуу Сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Эрүүгийн хуульд заасан дор дурдсан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогч /цаашид "Хохирогч" гэх/-д нөхөн төлбөр олгоход зарцуулна.

№	Эрүүгийн хуулийн зүйл, заалт	Эрүүгийн хуулийн зүйл, заалтын гэрчиг
1	81.1, 81.2	Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах
2	91.1, 91.2	Хүнийг санаатай алах
3	96.1, 96.2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах
4	108.3	Хүн хулгайлах
5	109.3	Хүнийг хууль бусаар хорих

6	112.3	Хүнийг барьцаалах
7	113.3	Хүн худалдаалах
8	126.2, 126.3	Хүчиндэх
9	147.3	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх
10	177.2	Зандалчлах
11	178.2	Терроризм
12	251.2, 251.3	Эрүү шүүлт тулгах

2.2. Сангийн удирдлага нь орон тооны бус Сангийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ байна.

2.3. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

2.4. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

2.5. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гүйцэтгэнэ.

2.6. Сан нь тогтоосон журмаар үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.7. Зөвлөл нь үйл ажиллагаандаа энэ журам болон Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг удирдлага болгоно.

2.8. Хуралдаанд гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хуралдаанд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд таслах эрхтэй оролцоно.

2.9. Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн дарга даргална. Даргын түр эзгүйд хуралдааныг даргын үүрэг болгосноор аль нэг гишүүн даргална.

2.10. Хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг нарийн бичгийн дарга оруулна.

2.11. Хуралдааны шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

2.12. Нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж, хуралдааны тэмдэглэлийг хөтөлнө.

2.13. Хуралдааны тэмдэглэлд дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Даргын түр эзгүйд хуралдсан хуралдааны тэмдэглэлд хуралдаан даргалагч гарын үсэг зурна.

Гурав. Өргөдөл гаргах, түүнд хавсаргах  
баримт бичиг

3.1. Нөхөн төлбөр хүсэх өргөдлийг хохирогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч /цаашид "өргөдөл гаргагч" гэх/ нь аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор маягтын дагуу гаргана.

3.2. Нөхөн төлбөр хүсэх өргөдлийн маягтын загварыг Зөвлөл батална.

3.3. Нөхөн төлбөр хүсэх өргөдлийн маягтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага үнэ төлбөргүй олгоно.

3.4. Өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

3.4.1. хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр болон гүйцэтгэх хуудсын хуулбар;

3.4.2. өргөдөл гаргагч иргэний баримт бичгийн хуулбар;

3.4.3. хохирлыг ялтан буюу түүний хууль ёсны төлөөлөгчөөс барагдуулаагүй, эсхүл дутуу барагдуулсныг нотлох баримт.

Дөрөв. Өргөдөл хянан шийдвэрлэх

4.1. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны ажилтан өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор энэ журмын 3.4-т заасан шаардлагыг хангасан эсэх, өргөдөл болон түүнд хавсаргасан баримт бичиг нь үнэн зөв эсэхийг тодруулж холбогдох баримтын бүрдлийг



ханган Зөвлөлд хүргүүлнэ.

4.2. Зөвлөл өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор эцэслэн хянаж дараахь санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

4.2.1. нөхөн төлбөр олгох;

4.2.2. нөхөн төлбөр олгохоос татгалзах.

4.3. Энэ журмын 4.2.1-д заасан санал, дүгнэлтийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

4.4. Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санал, дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 7 өдрийн дотор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.3-т заасны дагуу нөхөн төлбөр олгох шийдвэр гаргана.

#### Тав. Нөхөн төлбөр олгохоос татгалзах

5.1. Зөвлөл дараахь тохиолдолд болон Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т заасан үндэслэлийн аль нэг байвал нөхөн төлбөр олгохоос татгалзах санал, дүгнэлт гаргаж, өргөдөл гаргагчид албан бичгээр хариу мэдэгдэнэ:

5.1.1. өргөдөл гаргагч хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;

5.1.2. ялтан болон түүний хууль ёсны төлөөлөгч хохирлыг бүрэн барагдуулсан.

5.2. Хуурамч бичиг баримт бүрдүүлж, эсхүл худал мэдүүлж энэ журамд заасан нөхөн төлбөрийг авсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж, хохирлыг буцаан төлүүлнэ.

#### Зургаа. Нөхөн төлбөр олгох

6.1. Нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолд нэр нь заагдсан хохирогч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн банкин дахь харилцах /хадгаламжийн/ дансанд шилжүүлнэ.

Долоо. Нөхөн төлбөрийг гэм буруутай этгээдээр буцаан төлүүлэх

7.1. Сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх



тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу Санд буцаан төвлөрүүлнэ.

### Найм. Гомдол гаргах

8.1. Хохирогч нь нөхөн төлбөр олгох ажиллагаатай холбоотой гомдлоо Зөвлөлд гаргана. Зөвлөл нь уг гомдлыг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

8.2. Гомдлыг шийдвэрлэсэн Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч гомдлоо шүүхэд гаргаж болно.

8.3. Хохирогчид нөхөн төлбөр олгох үйл ажиллагаатай холбоотой маргаан үүссэн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн хохиролтой холбоотой нөхөн төлбөр олгох ажлыг түдгэлзүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 134

Улаанбаатар  
хот

### Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай

Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Засгийн газрын 2001 оны 157 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Сумын хөгжлийн сангийн үлдэгдэл хөрөнгийг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан Сум хөгжүүлэх санд шилжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

3. "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг



Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Сумын хөгжлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 157 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

Засгийн газрын 2011 оны 134 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ  
БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ  
ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Сумдад жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр байгуулах "Сум хөгжүүлэх сан" /цаашид "сан" гэх/-г бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, төсөл сонгон шалгаруулах, сангаас зээл олгох, эргэн төлүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Сан нь Төрийн санд тусгай данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ.

1.3. Сан нь Төрийн сангаас гадуур данстай байхыг хориглоно.

1.4. Сангийн орлого, зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгагдана.

1.5. Сангийн хөрөнгө нь сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь ергөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдана.

1.6. Сангаас иргэн, аж ахуйн нэгжид олгох хөнгөлөлттэй зээл нь дараахь нөхцөлтэй байх бөгөөд зээлийн хүүгийн хэмжээг энэхүү журмын 1.6.1-д заасан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шинэчлэн тогтоож болно.

1.6.1. хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дээд хэмжээ жилд 3 хүртэл хувь;

1.6.2. зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна.

1.7. Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй, эсхүл зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж төлүүлнэ. Торгуулийн хувь хэмжээ, нөхцөлийг сумын Засаг дарга, зээлдэгч нарын хооронд байгуулах гэрээнд тусгана.

1.8. Сангаас олгох зээлийн хүүгийн орлогын 50 хүртэл хувийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгуулагдсан төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлыг зохион байгуулах зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулж болно. Үлдэх хувийг сангаас олгох зээлийн эргэлтийн хөрөнгө болгож ашиглана.

1.9. Сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг нөхөн төлөх зэргээр энэхүү журмын 1.5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

#### Хоёр. Сангийн хөрөнгийн эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1. улсын төсвөөс олгох сумын хөгжлийн сангийн эргэлтийн хөрөнгө;

2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив;

2.1.3. иргэн, аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого.

2.2. Санд аймаг, сумын төсвийн хөрөнгө болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хэсгийн хөрөнгөөс хандивлахыг хориглоно.

2.3. Санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ, шаардлага зэргийг харгалзан Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын хамтарсан тушаалаар тогтооно.





## Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сангийн хөрөнгөөс зээл олгох, зарцуулах, хяналт тавих, зээлийг эргэн төлүүлэх, тайлагнахтай холбоотой дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн тодорхойлох;

3.1.2. сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлыг харгалзан тухайн санхүүгийн жилд сангаас олгох зээлийн хүүгийн хэмжээг энэ журмын 1.6.1-д заасан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байхаар жил бүр шинэчлэн тогтоох /тухайн санхүүгийн жилд хүүг шинэчлэн тогтоосон нь өмнөх жилүүдэд байгуулсан зээлийн гэрээнд тусгасан хүүг өөрчлөх нөхцөл болохгүй/;

3.1.3. тухайн санхүүгийн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;

3.1.4. төсөл сонгон шалгаруулахад сумын иргэдийн саналыг авах, түүнийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

3.1.5. сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус ажлын хэсгийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр ахлуулан байгуулна. Ажлын хэсгийг байгуулахдаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол гаргана;

3.1.6. сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэх.

3.2. Сумын Засаг дарга сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах арга хэмжээг авах;

3.2.2. санд ирүүлсэн төслүүдээс энэхүү журмын 3.1.1-д заасан чиглэлд нийцсэн, төсөл сонгон шалгаруулах зөвлөлөөс шалгаруулсан төсөлд зээл олгох шийдвэр гаргах;

3.2.3. төсөл нь шалгарсан иргэн, аж ахуйн нэгжтэй

зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах;

3.2.4. эргэн төлөгдсөн зээл, хүүгийн орлогыг сангийн дансанд төлөрүүлэх;

3.2.5. сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;

3.2.6. зээлийн хүүгийн орлогоос энэхүү журмын 1.8-д заасан зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, сумын жил бүрийн төсөвтэй хамт батлуулах;

3.2.7. сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах,

3.2.8. сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг энэхүү журмын 5.4-т заасан хугацаанд аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлэх.

3.3. Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулна. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг сумын Засаг дарга ахлах бөгөөд зөвлөлийн 3 гишүүн нь тухайн сумын иргэний төлөөлөл байна.

#### Дөрөв. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулах

4.1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг сонгон шалгаруулахдаа дараахь шалгуурыг харгалзан үзнэ:

4.1.1. тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх;

4.1.2. хүрэх үр дүн, зорилт нь тодорхой байх;

4.1.3. төслийн үр ашиг, гэрээний хугацаанд зээлээ эргэн төлөх боломжтой байх;



4.1.4. төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, эрсдэлийг даван туулах талаар тусгасан байх;

4.1.5. ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх.

4.2. Сангийн хөрөнгөөс зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дараахь шаардлагыг хангасан байна:

4.2.1. иргэн, аж ахуйн нэгж нь харъяаллын хувьд тухайн суманд бүртгэлтэй байх;

4.2.2. сум хөгжүүлэх сан болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй байх;

4.2.3. зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлээ хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай байх.

4.3. Энэхүү журмын 4.2-т заасан этгээд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслөө төсөл сонгон шалгаруулах зөвлөлд ирүүлнэ. Төсөл сонгон шалгаруулах хугацааг зөвлөл тогтооно.

4.4. Зөвлөл нь иргэн, аж ахуй нэгжийн ирүүлсэн төслийг энэхүү журмын 4.1, 4.2-т заасан шалгуур, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, зөвлөлийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор Засаг дарга зээл олгох захирамж гаргана.

4.5. Шалгарсан төсөлд зээл олгох тухай шийдвэрийг үндэслэн тухайн төслийг хэрэгжүүлэгч этгээдтэй сумын Засаг дарга зээлийн гэрээг "Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ын дагуу байгуулна.

4.6. Зээлийн гэрээг байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлнэ.

4.7. Иргэн, аж ахуйн нэгж олгосон зээлийн хөрөнгө, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд Сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлнө.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах, хяналт тавих

5.1. Сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод явуулна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад тухайн сумын

иргэд хяналт тавих эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно.

5.2. Сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг сумын Засаг дарга хариуцна.

5.3. Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна.

5.4. Сумын Засаг дарга сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний сарын 10-ны дотор аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлнэ. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар сумдын тайланг аймгийн хэмжээнд нэгтгэж, улирлын эхний сарын 20-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тайланг улсын хэмжээнд нэгтгэж улирлын эхний сарын 30-ны дотор Сангийн яаманд тус тус хүргүүлнэ.

5.5. Жил бүрийн сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, нэгдсэн дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яаманд ирүүлэх асуудлыг аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар хариуцаж ажиллана.

### Зургаа. Хариуцлагын тогтолцоо

6.1. Сангийн хөрөнгийг зарцуулах, зээл олгох, зээлийн хөрөнгийг ашиглах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Энэхүү журмын 4.2-т заасан этгээд авсан зээлээ үр ашиггүй зарцуулсан, эсхүл зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгжид сангаас дахин зээл олгохгүй.

6.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, чанаргүй төсөл сонгон шалгаруулсан, тэдгээрт зохих хяналт тавиагүй нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол сумын Засаг даргад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



Засгийн газрын 2011 оны 134 дүгээр  
тогтоолын 2 дугаар хавсралт

**СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ОЛГОХ ЗЭЭЛИЙН  
ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР**

20.. он...сар...өдөр

Дугаар...

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү зээлийн гэрээгээр сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, өргөтгөх, сэргээх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр төсөл боловсруулан шалгарсан иргэн, аж ахуйн нэгжид Сум хөгжүүлэх сангаас зээл олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Нэг талаас ..... аймгийн ..... сумын Засаг дарга ..... овогтой ..... /цаашид "зээлдүүлэгч" гэх/ нөгөө талаас ..... аймгийн ..... сумын иргэн, аж ахуйн нэгжийг төлөөлж ..... овогтой ..... /цаашид "зээлдэгч" гэх, хамтад нь "талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 281-286 дугаар зүйлд заасныг үндэслэн ..... /тоогоор, үсгээр/ төгрөгийн зээлийг дор дурдсан нөхцөлөөр олгохоор харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.3. Сангийн хөрөнгөөс зээл авахаар зээлдэгчийн шалгарсан төсөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

2.1. Сангаас олгох ..... /тоогоор, үсгээр/ төгрөгийн зээлийг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 1.5-д заасны дагуу ..... зориулалтаар зарцуулна.

2.2. Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлж дуусгана. Үүнд:

1. 20.. оны.....дугаар сарын .... өдөр .....төгрөг

2. 20.. оны.....дугаар сарын .... өдөр .....төгрөг

3. 20.. оны.....дугаар сарын .... өдөр .....төгрөг

4. 20.. оны .....дугаар сарын .... өдөр .....төгрөг гэх мэт

2.3. Зээлдэгч зээлийн үндсэн хүүг сарын..... хувиар тооцож, сар бүрийн эхний 7 хоногийн ажлын өдөрт багтаан сангийн ..... тоот дансанд төлнө.

2.4. Энэхүү гэрээний 2.2-т заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөөгүй, эсхүл зээл төлөх эцсийн хугацаа хэтэрсэн бол зээлийн хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэлд үндсэн хүүгээс гадна сарын .... хувийн торгууль төлнө.

#### Гурав. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Төсөл хэрэгжүүлэхэд зориулан .....төгрөгийн зээлийг сарын .... хувийн хүүтэйгээр олгоно.

3.2. Зээлийн хөрөнгийг зээлдэгч иргэн, аж ахуйн нэгжийн .....  
..... банк дахь ..... дансанд шилжүүлнэ.

3.3. Авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар төлүүлэх, зохих журмын дагуу зээлийг төлүүлэх шаардлагатай бусад арга хэмжээ авна.

3.4. Гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, зээл, хүүгийн төлөлтөд хяналт тавина.

3.5. Зээлдэгчийн хэрэгжүүлж байгаа төслийн явц, байдалтай тухай бүр танилцана.

3.6. Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ.

#### Дөрөв. Маргааныг шийдвэрлэх

4.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг оролцогч талууд харилцан зөвшөөрснөөр шийдвэрлэнэ.

4.3. Энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав. Бусад зүйл

5.1.....

5.2.....

5.3.....ГЭХ МЭТ

Гэрээний тал:

Зээлдүүлэгч.....

Зээлдэгч.....

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 4 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар  
хот

### Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "100.000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд иргэдийг орон сууцны зээлд хамруулах санхүүжилтийн загварыг хэвсрэлтээр баталсугай.

2. 50 м<sup>2</sup>-аас дээшгүй талбай бүхий орон сууц авахаар анх удаа хүсэлт гаргасан иргэдийг жилийн 6 хүртэл хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах харилцааг зохицуулах журмыг боловсруулан хамтран баталж, орон сууцаар хангах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт, хэрэгжилтэд нь байнгын хяналт тавьж ажиллахыг Орон сууцжуулах ажлыг эрчимжүүлэх Үндэсний хорооны дарга, Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.

3. Хөгжлийн банкны эх үүсвэрт авсан хүү болон арилжааны банкаар дамжуулан зээлдүүлж байгаа хүүгийн зөрүү, энэ үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

4. Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийг орон сууц худалдан авахад ашиглах хүсэлт гаргасан Монгол Улсын иргэнд төлбөрийн дансны бүртгэл хийх ажлыг зохион байгуулж, орон нутаг дахь захиалгыг тухайн аймгийн Засаг даргын Тамгын газраар гүйцэтгүүлэн, биелэлтийг нэгтгэх арга хэмжээ авахыг "Орон сууцны санхүүжилтийн корпораци" ХХК (Ж.Алдаржавхлан)-д үүрэг болгосугай.

5. Ипотекийн хоёрдогч зах зээлийг дэмжих зорилгоор санхүүжилтийн эх үүсвэртэйгээ уялдуулан Монголын Ипотекийн корпорацид урт хугацаат зээлийн санхүүжилт олгох асуудлыг судалж шийдвэрлэхийг Хөгжлийн банк (Ч.Хашнулуун)-нд зөвшөөрсүгэй.

6. Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийг орон сууц худалдан авахад ашиглахтай холбогдуулан шаардагдах хөрөнгийг тухайн жилийн Хүний хөгжил сангийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авч байхыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

7. Шинэ суурьшлын бүсэд орон сууц барихад шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**


**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Х.БАТТУЛГА**



Засгийн газрын 2011 оны 136 дугаар  
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

**50 М-ААС ДЭЭШГҮЙ ТАЛБАЙ БҮХИЙ ОРОН СУУЦ АВАМААР АНХ УДАА ХҮСЭЛТ  
ГАРГАСАН ИРГЭДИЙГ ОРОН СУУЦНЫ ХӨНГӨЛБӨЛТЭЙ ЭЗЭЛД ХАМИРУУЛАХ  
САНХҮҮЖИЛТИЙН ЗАЛВАР**



Орон сууцны эзэлийн өмчлөлт  
-Боловсрол олгох орон сууцны эзэл нь  
6 кустай хувийн хуулийн байр,  
-20-30 жилийн хугацаатай байр,  
-Нэгдэл 1 сая төгрөгийн үржүүлэгээр  
Хүний хөгжлийн сангаас олгох.  
-Анх удаа орон сууцны эзэл авч  
байгаа бөгөөд өөрийн орон сууцны  
күлгэнд эзэл олгох.

**Тайлбар**  
1.Иргэн Хүний хилийн хувирын 1 сая төгрөгийг бэлтгэн бэлтгэх үйлдвэр  
2.ОССХ үндэстэй төрөлх өргөмж  
Бүтээлийн хийж, Арилзаны  
Бэлтгэл үйлдвэр  
3.ОССХ-ийн санхүүг үндэстэй  
Арилзаны Банк өргөмж өмчлөх  
6 кустай хуулийн хуулийн орон  
сууцны эзэлийн өмчлөлт  
4.Мэргэжлийн тууштай үндэстэй  
Лийн төрийн төлөөллийн ажил  
мэргэжлийн орон сууцны эзэл, мөрдүүлэх  
тууштай ОССХ үйлдвэр

**Хаяг:**  
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_mededecl@parliament.mn  
Утас: 262420, 329612  
Хүчтэйгээр зүүрс 5.5  
Индекс: 14003

